



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 10 сар | Дугаар 23

ГАРЧИГ

- 2-4 Бодлогын нийтлэл
- 4-6 Зохицуулалтын мэдээ
- 7-8 Санхүүгийн зохицуулах хороо ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавруудыг амжилттай биелүүллээ
- 9 Давхар даатгалын талаар
- 10 Финтек ба ретек
- 11-15 Банк бус санхүүгийн байгууллагын ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдал, сайжруулах боломж
- 16 Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо
- 17-18 Өргөн дуран
- 19 Гүйлгээг сэжигтэй гэж үзсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?
- 20 Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах
- 21 Хямралын үе дэх компанийн засаглал
- 22-23 ОУ-ын хөрөнгийн зах зээлийн мэдээ
- 24-27 Санхүүгийн зах зээлийн сарын мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ФАТФ-ААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРУУДЫГ АМЖИЛТТАЙ БИЕЛҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны ахлах хянан шалгагч **У.Ганчимэгтэй** ярилцлаа.

Сайн байна уу? ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гарсан тухай мэдээлээд байна. Саарал жагсаалтаас гарахад чухамдаа Санхүүгийн зохицуулах хороо ямар үүрэг, оролцоотой ажилласан бэ?

Одоогоос яг нэг жилийн өмнө буюу 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ФАТФ буюу Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага Монгол Улсыг стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-д оруулж, үр дүнтэй байдлын 4 шууд хэрэгжилтийн хүрээнд 6 ажлын даалгавраар хугацаатай үүрэг даалгавар өгснөөс дараах ажлууд Санхүүгийн зохицуулах хороонд шууд хамааралтай байсан. Үүнд:

(1) Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагчид байгууллагын эрсдэлийг ойлгож, эрсдэлийн түвшинд тохируулж хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг тодорхойлох, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулах;

(2) Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах.

Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор 2019 онд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалтаас гаргах Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, Санхүүгийн зохицуулах хорооноос уг ажлын хэсэгт

ажиллаж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлд онцгой ач холбогдол өгч ажилласан бөгөөд энэ чиглэлээр нэн даруй хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шат дараалсан арга хэмжээнүүдийг авч, гүйцэтгэсэн ажлуудаа ФАТФ-т амжилттай тайлагнаж, үүрэг даалгавруудыг бүрэн хэрэгжүүлээд байна.

ФАТФ-аас өгсөн дээрх үүрэг даалгавруудыг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлсэн голлох ажлуудыг дурдвал?

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох заавар, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулж ажилласан бөгөөд 2020 оны 179 дүгээр тогтоолоор “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг шинээр баталж, бүх салбарт хэрэгжүүлж байна.

Санхүүгийн зохицуулах хороо эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг өөрийн зохицуулалттай 6 салбаруудад нэвтрүүлэх ажлыг авч хэрэгжүүлсэн. Ингэхдээ зохицуулалттай салбар тус бүрийн эрсдэлийг үнэлэх, түүний үр дүнд суурилж мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрээр эрсдэлийг үнэлэх ажлыг хийсэн.

Саарал жагсаалтад орсноос хойш Санхүүгийн зохицуулах хороо нийт 227 удаа мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдалд 78 улсын байцаагчийг албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Үргэлжлэл 7-р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.




БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО

Эрх зүйн зохицуулалт: Монгол Улс ардчилсан тогтолцоо руу шилжилт хийхийн зэрэгцээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд нэгэн зэрэг хос шилжилтийг эхлүүлсэн бөгөөд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилготойгоор 1992 онд Монгол Улсын ардчилсан шинэ үндсэн хуулиа баталсан. Монгол улсын иргэн хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхийг энэхүү

Үндсэн хуулиар олгосноор үл хөдлөх хөрөнгийн салбар манай улсад үүсэж хөгжих үндэс суурь тавигдсан.

Манай улсын хувьд үл хөдлөх хөрөнгийн салбар нь нийгэм-эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой салбарын нэгд зүй ёсоор тооцогдох болсон бөгөөд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа нь 2019 оны байдлаар нэрлэсэн ДНБ-ий 5.3 /2019 оны статистикийн мэдээлэл/ хувийг бүрдүүлж байна.



2000 2001 2002 2003 2004 2005 2006 2007 2008 2009 2010 2011 2012 2013 2014 2015 2016 2017 2018 2019

Үл хөдлөх эд хөрөнгө түүнтэй холбоотой харилцаа нь Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулагдсаар ирсэн. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуульд иргэний хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг;
- Иргэний хуульд үл хөдлөх хөрөнгө өмчлөх, түүнтэй холбоотой харилцааг;
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулахтай холбогдон үүсэх харилцааг;
- Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд газар өмчлөл, ашиглалт, эзэмшихтэй холбогдсон харилцааг болон бусад холбогдох хууль тогтоомжуудад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлтэй

холбогдсон эдийн засаг, эрх зүйн харилцааг зохицуулсан байна.

Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 20 дахь удаагийн ээлжит хурлаар Монгол Улсын мөнгө угаах, терроризмтой тэмцэх тогтолцоонд Харилцан үнэлгээг хийж, үнэлгээний тайланг хэлэлцэж баталсан бөгөөд нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг өгсөн. Үүний дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой ажлын хүрээнд 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан “Мэдээлэх үүрэгтэй этгээд”-ийн хүрээг Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 40 зөвлөмжид нийцүүлэн өргөжүүлж, үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах аливаа ажиллагааг эрхэлж буй хуулийн этгээдийг хамруулсан.

ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулж, хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх үүрэг даалгаврын нэг нь үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тус тус нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

СЗХ нь хуулиар олгогдсон эрх үүргийнхээ хүрээнд 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”, мөн оны 181 дүгээр тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг тус тус баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өнөөгийн байдал: СЗХ-ны 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан. Энэхүү журмаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг хянаж, зохицуулснаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх, далд эдийн засгийг ил болгох, тодорхойгүй мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх, уг салбарт учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт 6,928 хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийн

чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүртгэлтэй боловч тогтмол буюу байнгын үйл ажиллагаа явуулдаг нь цөөхөн.


Эдгээр аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлэх ажил коронавирусын халдварт (КОВИД-19) цар тахлын үетэй давхацсан хэдий ч СЗХ-ноос шуурхай ажиллаж журамд заасан нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан 146 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож, 46 аж ахуйн нэгжээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн хүсэлт болон холбогдох баримт бичгийг хянаж байгаа бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран дээрх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ СЗХ-нд ирүүлээгүй 6,728 хуулийн этгээдийн үйл ажиллагааных нь чиглэлээс үл хөдлөх эд хөрөнгийн худалдаа,

зуучлал, түрээс зэрэг үйл ажиллагааг нь бүртгэлээс хассан. Цаашид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээг авч ажиллана.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт тусгай зөвшөөрөлтэйгөөр 103 хуулийн этгээд 153 хувьцаа эзэмшигчийн 1,872,772.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 10,549,182.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн хугацаанд 399 хэлцлээр 49,226,098.6 мянган төгрөгтэй тэмцэх хэмжээний үл хөдлөх эд хөрөнгийг борлуулах хэлцэл хийгдсэн байна.



Улаанбаатар хотод борлуулагдсан үл хөдлөх эд хөрөнгийн үнэ дүүргээр:



Үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлд нэгэн шинэ бүтээгдэхүүн “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн үүсгэн байгуулсан “НОСК нэг ТЗК” ХХК-аас орон сууцны түрээсийн үйл ажиллагаанд суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бөгөөд түрээсийн орлогоор баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 34.3 тэрбум төгрөгийн баталгаат үнэт цаасыг бүртгэсэн явдал юм.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2018”-д үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын

салбарт 770 хүн ажиллаж байсан бол 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 1,103 хүн ажилладаг гэсэн өссөн үзүүлэлт байна. Үл хөдлөх эд хөрөнгийн салбар нь асар том зах зээл бөгөөд улс орны эдийн засаг, ДНБ-д чухал нөлөөг үзүүлдэг тул энэ салбарыг зөв замд нь оруулахын тулд санхүүгийн зах зээлтэй уялдуулах, үл хөдлөх эд хөрөнгийн санхүүжилттэй холбож цогц байдлаар хөгжүүлэхэд тусгайлсан хуулийн зохицуулалттай байх шаардлага урган гарч байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ: СЗХ–ны зохицуулалтад шинээр хамаарах болсон дээрх төрлийн үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээдийн тоо нэмэгдэх хандлагатай тул СЗХ цаашид дараах бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын

байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг боловсруулах буюу бие даасан хуулийн зохицуулалттай болгох;

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд зайны хяналт, шалгалтыг хялбаршуулах, үл хөдлөх хөрөнгөтэй холбогдон гарах төлбөрийн баримтыг нэгдсэн системээр бүртгэх

ажлыг эхлүүлэх;

- Дэвшилтэт технологийг ашиглан цахим үйлчилгээний нэгдсэн системийг бий болгож, зохицуулалттай этгээдийг ил тод мэдээллээр хангах;
- Төрийн үйлчилгээнд цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх орчныг бүрдүүлэн, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөсөн.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ИРГЭД, БАЙГУУЛЛАГУУД САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ “E-MONGOLIA” НЭГДСЭН СИСТЕМЭЭС АВДАГ БОЛНО



Санхүүгийн зохицуулах хороо үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-д нэгдэхээр боллоо. Тодруулбал, Санхүүгийн зохицуулах хороо Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг байгууллаа. Уг арга хэмжээнд Хорооны дарга Д.Баярсайхан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ болон албаны бусад хүмүүс байлцлаа.

Хорооны дарга Д.Баярсайхан уг арга хэмжээг нээж “Хороо үндэсний цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-д нэгдэх ажлыг эхлүүлснээр банкнаас бусад санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг цахимжуулах боломж бүрдэж байна. Ингэснээр Хороо болон зохицуулалттай байгууллагуудын ажил, үйлчилгээ иргэд, аж ахуйн нэгжүүдэд илүү ойртох, нээлттэй болох, иргэдийн санхүүгийн хүртээмж нэмэгдэх боломж, бололцоо бий болно. Тэр тусмаа техник технологи өндөр хөгжиж байгаа энэ үед санхүүгийн салбарыг шинэ шатанд хүргэх, илүү хялбар, түргэн шуурхай болгох Финтек үйлчилгээнүүдийг бойжуулах зориулалттай Сэндбокс орчныг хөгжүүлэх үйлчилгээ илүү хүртээмжтэй болно. Мөн цахим гарын үсэгт үндэслэн хадгаламжийн гэрээ, зээлийн гэрээ, барьцааны гэрээ, даатгалын гэрээ гээд санхүүгийн харилцааг зохицуулдаг маш олон гэрээг цахимаар хийх боломж бүрдэнэ” гэдгийг онцолсон юм.

Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт

тусгагдсан зорилтуудыг хамтран хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах, банкнаас бусад санхүүгийн салбарыг цахимжуулах нь энэхүү санамж бичгийн гол зорилго юм. Тодруулбал, банкнаас бусад санхүүгийн байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд гаргадаг лавлагаа, тодорхойлолтууд болон бусад холбогдох үйлчилгээг төрийн үйлчилгээний цахим машин (ТУЦ машин), төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-аас авах, зохицуулалтын байгууллагуудын төлбөр тооцоо бүхий үйлчилгээг уг системээр үзүүлэх цаашилбал хадгаламжийн гэрээ, зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон бусад холбогдолтой гэрээнүүдийг цахим гарын үсэгт суурилж гүйцэтгэх, үнэт цаасны зах зээл, арилжааг цахимжуулах, хөрөнгийн зах зээлд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх давуу талтай юм.

АНХНЫ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЦАНГ ЦОХИЛОО



Монгол Улсад анхны хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд арилжаалах цан цохих ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын ажиллагаанд санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Байгалмаа, “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг болон албаны бусад хүмүүс оролцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж “2013 онд УИХ-аас Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооноос тус хуулийг дагаж гаргах шаардлагатай дүрэм, журмыг баталснаар хөрөнгө оруулалтын сан сонгодог утгаар хөгжих эрх зүйн үндэс

бүрдсэн. Хөрөнгө оруулалтын хамтын сан буюу олон нийтээс татсан хөрөнгөөр шууд хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгө оруулалтын сангийн тогтолцоо манай улсад харахан бүрдээгүйгээс анхдагч зах зээлд амжилттай арилжаалсан үнэт цаасны үнэ ханш хоёрдогч зах зээлд дээр унах, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглал, тайлагналын ил тод байдал сайжрахгүй байх, хөрөнгө оруулагч хүссэн бодит өгөөжийг хүртэж чадахгүй байх асуудал үүсэж байна. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооноос санаачлан УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д “Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэврийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох” арга хэмжээг тусгуулсан бөгөөд дээрх арга хэмжээг бодит ажил хэрэг болгох чиглэлээр төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар 20 гаруй хувийн хөрөнгө оруулалтын сангийн бичиг баримтыг бүртгэж, 23 компани Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас “Ард менежмент ҮЦК” ХХК-аас үүсгэн байгуулсан “Үндэсний хувьчлалын сан” нь хөрөнгийн зах зээлд анхны хамтын хөрөнгө оруулалтын сангийн гарааг амжилттай эхлүүлснээр цаашид хамтын сангууд олноор байгуулагдах суурь болно гэж харж байна” гэсэн юм.

Үндэсний хувьчлалын сан, хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх нь тус бүр 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бөгөөд 50 сая ширхэг нэгж эрх гаргаж, үүнийхээ 95 хувийг буюу 47 сая 500 мянган ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгож буй аж. Хөрөнгө оруулагчид өөрсдийн харилцдаг үнэт цаасны компаниараа дамжуулан Хөрөнгийн бирж дээрээс сангийн нэгж эрхийг худалдан авах боломжтой бөгөөд нэгж эрхийг худалдан авч буй иргэд, аж ахуйн нэгжийн хувьд хөрөнгө оруулалтын бодит эрсдэл, өгөөж, ногдол ашгийн бодлогын талаарх мэдээллийг хөрөнгө оруулалтын менежментийн компани, брокерийн компаниар дамжуулан үнэ төлбөргүйгээр авч дээрх мэдээлэлд тулгуурлаж хөрөнгө оруулалт хийх боломжтой юм.

ГУДАМЖИНД, ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ВАЛЮТЫН АРИЛЖАА ХИЙХИЙГ ТАСЛАН ЗОГСООНО



Санхүүгийн зохицуулах хороо гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ-уудын үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлсон “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг энэ оны 6 дугаар сард баталсан. Ингэснээр тусгай зөвшөөрөлтэй 154 ББСБ төрийн мэдээллийн “ХУР” системээр харилцагчийг таньж мэдэх, иргэд байгууллагуудад НӨАТ-ын баримт олгох зохицуулалт

бүрдсэн. Тодруулбал, иргэд валют худалдах эсвэл худалдан авах бүрт төлбөрийн и-баримтыг шаардаж авах, валютын арилжаа эрхлэгчдийн хувьд ч энэхүү баримтыг заавал өгөх үүрэг хүлээсэн.

Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсон нэг шалтгаан нь одоогийн валютын арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой. Иймээс Санхүүгийн зохицуулах хороо “Найман шарга” төв болон гадаад валютын арилжаа эрхэлдэг нэр бүхий ББСБ-уудад мөнгөн хөрөнгийн бүтцийг нь тодорхойлох, валютын арилжаа эрхлэх нөхцөл, шаардлагын хэрэгжилт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүргийн биелэлтийг хангаж ажиллаж байгаа эсэх, гудамжинд, зөвшөөрөлгүйгээр валютын арилжаа хийдэг байдлыг таслан зогсоохоор хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Учир нь дээрх журамд гадаад валютын арилжаа нь хуулиар олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аюулгүй байдлыг хангасан тодорхой нөхцөл, шаардлага бүхий ажлын байр, үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг нарийвчлан тогтоож өгсөн. Түүнчлэн хувийн дансаар дамжуулан арилжаа хийх, санхүүгийн тайланд бүртгэлгүй, зөвшөөрөгдөөгүй мөнгөн хөрөнгөөр арилжаа хийхгүй байх нөхцөлийг бүрдүүлснээр ББСБ-уудын санхүүгийн сахилга бат сайжрах, орлого, зардлаа үнэн бодитой тодорхойлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бий болно.

ГАМШГИЙГ УДИРДАХАД ДААТГАЛЫН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙН ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Хүртээмжтэй даатгалын асуудлаар Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээ (MEFIN) хамтран уламжлал болгон зохион явуулдаг олон улсын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг боллоо.

Өнгөрсөн 9 дүгээр сарын 29,30-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион явуулсан ес дэх удаагийн энэхүү уулзалт хэлэлцүүлэг “Уур амьсгалын болон гамшгийн цар тахлын эрсдэлийг бууруулах нь” сэдвийн хүрээнд болсон бөгөөд Хүртээмжтэй даатгалын асуудлаар Азийн орнуудын мэдлэг туршлага солилцох сүлжээний гишүүд болон даатгалын салбарын мэргэжилтэн, зохицуулах байгууллагын төлөөлөл зэрэг нийт 70 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон юм. Уулзалт хэлэлцүүлэгт Монгол Улсаа төлөөлөн Санхүүгийн зохицуулах хороо, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооны төлөөлөл оролцож санал бодол, туршлага, мэдлэгээ солилцлоо.

Энэ удаад даатгал, хамгаалах систем албан бус секторт дутагдаж буй суурь болох нь, албан бус секторын олон талт байдал ба даатгалд хамрагдах арга зам, эрэлтэд суурилсан гамшгийн эрсдэлийг санхүүжүүлэх шийдлүүд, тэдгээрийн хэрэгцээ, эмзэг байдлыг бууруулах, гамшгийг удирдахад даатгалын салбарын гүйцэтгэх үүрэг гэсэн үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэлэлцсэн юм. Тодруулбал, татвар, хуулийн зохицуулалтаас гадуур, далд эдийн засгийн чанартай, тогтворгүй шинжтэй байнгын бус үйл ажиллагаа явуулдаг, ажлын нөхцөл, нийгмийн хангамж муутай салбар буюу албан бус секторт дутагдаж буй даатгалын хамгаалалт, энэ секторт хэнийг хамруулах, тэдэнд тулгарч буй асуудал болон эмзэг байдал, бага дунд орлоготой иргэдийн гамшгийн нөлөөнд тэсвэрт байдлыг сайжруулах зорилгоор нийгмийн даатгал, хамгаалалтын бусад арга хэрэгслийг хүртээмжтэйгээр нэмэгдүүлэх арга замуудын тухай хэлэлцлээ. Мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой даатгал

нэвтрүүлсэн улс орнууд болох Марокко, Этиоп улсуудын RAMED, Productive Safety Net зэрэг өрхийн санхүүгийн тогтвортой байдал болон гэнэтийн эрсдэлд тэсвэртэй байдлыг дэмжсэн, эерэг үр дүн гарсан хөтөлбөрүүдийг танилцууллаа.

Энэхүү уулзалт хэлэлцүүлэгт дурдагдсан олон улсын туршлага, шийдэл нь хүртээмжтэй даатгалыг өргөжүүлэн хөгжүүлэх, тэр дундаа манай улсын хувьд нэн шаардлагатай гамшгаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх мөн даатгалын салбарын оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой санал санаачилга, сайн туршлага болж чадсан юм.

“САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЦАГ” ЭЭЛЖИТ РАДИО НЭВТРҮҮЛЭГ БОЛЛО



Санхүүгийн зохицуулах хороо Монголын үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран долоо хоног тутмын “Санхүүгийн зах зээлийн цаг” радио нэвтрүүлгийг явуулж байгаа бөгөөд ээлжит дугаарт “Банк бус санхүүгийн байгууллагын ач холбогдол”, “Хувьцаа-1072”, “Хөрөнгийн зах зээл”, “Үнэт металл, үнэт чулууны арилжааны эрх зохицуулалт” сэдвээр явагдаж Хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Ж.Байгалмаа, Хорооны Үнэт цаасны газрын ахлах референт Б.Дөлгөөн, Үнэт металлын үндэсний холбооны гүйцэтгэх захирал Г.Мөнхцэцэг нар оролцож мэдээлэл өглөө.

ХОРОО МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДТОЙ ХАМТРАН ЭЭЛЖИТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



- Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институттэй хамтран 2020 оны 9 дүгээр сарын 23–24-ны өдрүүдэд “Даатгалын байгууллагад аудит хийх” болон “Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх” аудитуудад зориулсан цахим сургалт;
- Монголын даатгалын холбоотой хамтран 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр даатгалын төлөөлөгчийн сургалт;
- Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоо хамтран 2020 оны 10 дугаар сарын 8–10-ны өдрүүдэд даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалт;
- Монголын банкны холбоо болон Монголын даатгалын зуучлагчдын холбоотой хамтран 2020 оны 10 дугаар сарын 13–20-ны өдрүүдэд даатгалын зуучлагчийн эрх олгох сургалтыг тус тус зохион байгууллаа.



БАЙР СУУРЬ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ФАТФ-ААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРУУДЫГ АМЖИЛТТАЙ БИЕЛҮҮЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны ахлах хянан шалгагч У.Ганчимэгтэй ярилцлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбаруудын, тэр дундаа санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүлийн нэг жилийн хугацаанд 2,900 гаруй этгээдэд танхимын сургалт ороод байна. Санхүүгийн зохицуулах хороо нийт зохицуулалттай салбаруудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр нийт 54 сургагч багшийг бэлтгээд байна. Үүнээс гадна цахимаар, олон нийтийн сүлжээгээр салбарын оролцогчдод мэдээлэл хүргэх, гарын авлага боловсруулж, тараах, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг авч хэрэгжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн шинэ 2 салбар хамаарах болсонтой холбоотойгоор Үндэсний статистикийн хороотой үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх зорилгоор 2019 оны 12 дугаар сард байгуулсан гэрээний хүрээнд хамтран ажиллаж, эрсдэлд суурилсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх хяналт шалгалтыг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэв.

Хамтын ажиллагааг өргөжүүлэх,

техникийн туслалцаа авах, албан хаагчдыг чадавхжуулах чиглэлд Хороо идэвхтэй ажиллаж байна. Дотоод хамтын ажиллагааны хүрээнд Хороо Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, Терроризмтой тэмцэх зөвлөлийн гишүүнээр ажилладаг бөгөөд холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо Азийн хөгжлийн банкнаас техникийн туслалцаа авч, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх албаны үйл ажиллагааны гарын авлага, албан хаагчдад зориулсан сургалт, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын эрсдэлийн үнэлгээтэй холбоотой арга зүйн туслалцаа авч ажилласан. Түүнчлэн, Дэлхийн банкнаас техникийн туслалцаа авч, Мөнгө угаахтай тэмцэх албыг бэхжүүлэх чиглэлээр гадаадын болон дотоодын зөвлөхийг авахаар ажиллаж байна. OECD /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/-аас үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг идэвхжүүлэх, алтны нийлүүлэлтийн сүлжээг ил тод болгох, албажуулах, сургалт зохион байгуулах, албан хаагч, ажилтнуудыг чадавхжуулахад туслалцаа хүсэж, техникийн туслалцаа авах чиглэлээр ажиллаж байна.

Хорооноос авч хэрэгжүүлсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх салбарын эрсдэлийн үнэлгээ, үндэсний эрсдэлийн үнэлгээ ямар ялгаатай вэ?

ФАТФ-ын Техникийн зөвлөмж 1-д “Улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлж, үнэлж, ойлгох шаардлагатай бөгөөд эрсдэлээ үнэлэх эрх бүхий байгууллагыг тодорхойлж, энэ талын зохицуулалтыг хийж, нөөц бололцоог зөв хуваарилах, эрсдэлээ үр дүнтэй бууруулах арга хэмжээ авбал зохино. Эрсдэлийн үнэлгээнээс эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх замаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн төвшинд тохирсон урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах

шаардлагатай” гэж заасан.

Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо анх удаа өөрийн зохицуулалтын 6 салбар буюу банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбаруудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх салбарын эрсдэлийн үнэлгээг 2019 онд хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран хийсэн. Ингэхдээ зохицуулалттай салбар тус бүр үйл ажиллагааны төрөлхийн эрсдэлийг үнэлж, эрсдэл үүсэх давтамж, эрсдэл үүссэн тохиолдолд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн. Үнэлгээг авч хэрэгжүүлэхдээ хувийн хэвшил, холбогдох бусад төрийн байгууллагуудаас санал, дүгнэлт авч тайланг боловсруулсан бөгөөд үр дүнг салбарын оролцогчдод танилцуулж, Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтын салбар тус бүрт баримтлах бодлогыг тодорхойлж ажиллалаа.

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хамгийн анх 2016 онд авч хэрэгжүүлсэн. Энэ үнэлгээг шинэчлэхтэй холбоотой 2020 оны 4 дүгээр сард Сангийн сайдын тушаалаар Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны аргачлалаар нийт 10 модуль буюу салбар, чиглэлийн хүрээнд үнэлгээг хийж байгаа бөгөөд эдгээрээс 6 модулийг Хороо 82 гишүүний бүрэлдэхүүнтэй хариуцаж ажиллаж байгаа бөгөөд Хороо өөрийн бүх зохицуулалттай салбаруудад үнэлгээг авч хэрэгжүүлж байна. 2020 оны Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар авч хэрэгжүүлж байгаагаас гадна мэргэжлийн холбоод, зохицуулалттай салбаруудын төлөөллийг ажлын хэсэгт хамруулж, холбогдох дата, статистик тоо мэдээг олон төрлийн эх үүсвэрээс цуглуулж, баталгаажуулж ажиллаж байгаагаараа онцлогтой. Эрсдэлийн үнэлгээний тайланг салбарын оролцогчдоор хэлэлцүүлж, тайлангийн төслийг боловсруулаад байна.

ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан хэдий



ч үр дүнтэй тогтолцоог хэвээр хадгалж үлдээх, олон улсын стандартыг хангаж ажиллах шаардлагатай. Эрсдэлийг үнэлэх нь эрсдэлийн тодорхойлж, үнэлгээний үр дүнд илэрсэн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, стратеги боловсруулж хэрэгжүүлэх, ФАТФ-ын дараагийн буюу 2023 онд хийгдэх үнэлгээнд бэлтгэхэд туслалцаа үзүүлэх ач холбогдолтой.

Эдгээр ажлуудыг шалгах баг Монгол Улсад ажиллалаа. ФАТФ-ын газар дээрх шалгалт хэрхэн хийгдсэн бэ?

ФАТФ-ын газар дээрх шалгалт нь хийгдсэн ажлуудыг баримтад тулгуурлаж шалгах, зохицуулалттай этгээдүүдтэй уулзаж, тэдгээрийн мэдлэг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, зохицуулагч байгууллагын хэрэгжүүлсэн ажлын үр дүнтэй байдлыг хэмжих зорилготой. Манай улсад ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын баг 2020 оны 10 дугаар сарын 01-нээс 02-ны өдрүүдэд хүрэлцэн ирсэн бөгөөд Газар дээрх шалгалтын багтай Хорооны удирдлага, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх албаны хариуцсан албан хаагчдаас гадна салбар тус бүрийн төлөөллийг буюу нийт 14 мэдээлэх үүрэгтэй этгээдтэй уулзаж, ФАТФ-ын стандартыг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийгдсэн ажлуудыг баримт бичигт үндэслэн тайлагнав. 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан Олон улсын хамтын ажиллагааны Хяналтын бүлгийн хурлаар Монгол улсыг өгсөн төрийн дээд хэмжээний амлалтаа биелүүлж, газар дээрх хяналт шалгалтыг Ковид-19 цар тахлын үед өндөр зохион байгуулалттай, дэлхийн жишиг

болохуйц хэмжээнд зохион байгуулсныг онцолсон.

ФАТФ-ын саарал жагсаалтаас гарсан тухай албан ёсны мэдээлэл гарсан байна?

ФАТФ-аас 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр өөрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтаас гаргасныг албан ёсоор зарлалаа. Ингэснээр манай улс ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавруудыг хамгийн богино хугацаанд буюу 6 сарын дотор амжилттай биелүүлсэн орон болоод байна.

ФАТФ-ын техникийн хэрэгжилтийн зөвлөмжүүдийн хувьд Хорооноос ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бэ?

Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/ нь ФАТФ-ын бүс нутгийн байгууллага бөгөөд Ази, номхон далайн бүсийн нийт 41 улс, олон улсын байгууллага болон ажиглагч байгууллагуудыг нэгтгэсэн олон улсын хамтын ажиллагааны байгууллага юм. Манай улс АНБМУТБ-ийн гишүүн орны хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ олон улсын стандартыг биелүүлэх үүрэгтэй. ФАТФ-аас 2016 онд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тогтолцоо, үр дүнтэй байдлын хэрэгжилтийг үнэлж, Харилцан үнэлгээний тайланг 2017 онд баталж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо буюу ФАТФ-ын 40 зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй гэж дүгнээд үүнээс 40 зөвлөмжийн 5-ыг биелүүлээгүй, 15-ыг нь хагас биелүүлсэн гэж дүгнэсэн. Иймээс дээрх 20 зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх зорилгоор Хоёрдугаар явцын тайланг 2019

онд хүргүүлж, эдгээрийн 16 зөвлөмжийн үнэлгээг 1-2 шатаар ахиулсан.

Санхүүгийн зохицуулах хороонд нийт 40 зөвлөмжийн 25 нь шууд болон шууд бус хамааралтай ба өнгөрсөн оны Хоёрдугаар явцын тайлангаар хэсэгчлэн биелүүлсэн болон биелүүлээгүй үнэлгээтэй 4 зөвлөмжөөс Зөвлөмж 14 /Мөнгө болон үнэ бүхий зүйлийн шилжүүлэг/ болон Зөвлөмж 28 /Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн хяналт шалгалт/-ийг хариуцаж ажиллалаа. Зөвлөмж 14-ийн үнэлгээг ахиулах зорилгоор зөвшөөрөлгүй мөнгөн гуйвуулгыг илрүүлэх, шийтгэлийн хэмжээг зөрчилтэй уялдуулан тогтоох, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх чиглэлээр Хорооноос Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг холбогдох байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажилласан. Харин Зөвлөмж 28-ийн үнэлгээг ахиулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, УИХ-аар батлуулсан бөгөөд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв. Ийнхүү Санхүүгийн зохицуулах хорооноос дээрх зөвлөмжүүдийн үнэлгээг ахиулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд энэ сарын 04-ний өдөр АНДМУТБ-ээс Монгол Улсын Гуравдугаар явцын тайланг баталж, Зөвлөмж 14-ийг 2 шатаар ахиулж “бүрэн биелүүлсэн”, Зөвлөмж 28-ийг 1 шатаар ахиулж “ихэнхийг биелүүлсэн” гэж дүгнэсэн.

Ярилцсанд баярлалаа.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ДАВХАР ДААТГАЛЫН ТАЛААР



Даатгалын тухай хуульд тодорхойлсноор “Давхар даатгалын үйл ажиллагаа гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг ойлгоно” гэсэн байдаг.

Монгол Улсад давхар даатгалын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараах даатгагчид даатгуулж болдог. Үүнд:

1. Даатгалын тухай хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид;
2. Даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид.

Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөө гаргаж, Даатгалын багц дүрэмд заасны дагуу Хороонд ирүүлэх бөгөөд уг даатгалын төлөвлөгөөг Хороонд ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын асуудал эрхэлсэн газар хянаж, даатгагчид хариуг хүргүүлдэг.

Даатгалын багц дүрэмд заасны дагуу Давхар даатгалын төлөвлөгөө нь давхар даатгалын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

Давхар даатгалын стратеги төлөвлөгөө нь тухайн даатгагчийн давхар даатгалын бодлогыг тодорхойлох үндсэн баримт бичиг бөгөөд даатгагчийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөл эсвэл хувьцаа эзэмшигчдээр батлуулдаг.

Давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана:

- Даатгагчийн хүлээж болох нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх эрсдэлийн дээд хэмжээг тодорхойлох нөхцөл;



- Давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийг сонгох, түүний үйл ажиллагааны найдвартай, хэвийн байдлын талаар үнэлэлт, дүгнэлт гаргах үйл ажиллагааны талаар;
- Давхар даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт, тайлагнал, дотоод хяналтын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, давхар даатгалын үйл ажиллагааг хариуцаж ажиллах боловсон хүчний нөөцийн талаар.

Давхар даатгалын жилийн төлөвлөгөө нь даатгагчийн тухайн жилд хэрэгжүүлэх давхар даатгалын үйл ажиллагааны төлөвлөлтийг тодорхойлох баримт бичиг байх бөгөөд даатгагчийн давхар даатгалын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөл эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулна.

Давхар даатгалын жилийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгана.

- Даатгагчийн хүлээж чадах нийт эрсдэлийн дээд хязгаар болон даатгалын нэг гэрээгээр хүлээх эрсдэлийн дээд хэмжээг давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд заасан аргачлалын дагуу тодорхойлсон талаар;
- Хамтарч ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагч нарын жагсаалт;
- Давхар даатгуулах үйл ажиллагааг эрхлэх, түүний хяналт, тайлагналын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар;
- Өөрт үлдээх даатгалын эрсдэлийн хязгаар (даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн тус бүрээр);
- Факультатив болон гэрээт давхар даатгалд хамруулах даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн, давхар даатгалын хэмжээ гэх мэт.


Давхар даатгал бол өөрийн хөрөнгийг бусдын хөрөнгөөр хамгаалуулж байгаа хэлбэр юм.

ФИНТЕК БА РЕГТЕК

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс хагас жил тутам гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тоймын 2020 оны хагас жилийн дугаар 9 сард нийтлэгдсэн байна. “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэхүү дугаарт дээр дурдсан тоймын мэдээллээс хүргэе.

2020 оны эхний хагас жилд дэлхий даяар нийт 25.6 тэрбум ам долларын хөрөнгө оруулалтын 1,221 удаагийн хэлцэл хийгдсэн байна. Том компаниуд нэгдэж, нийлэх хэлцэл 2019 оноос огцом буурсан байгаа нь 2020 онд нийт хэлцлийн хэмжээ, тооны үзүүлэлт буурсныг тайлбарлаж байна. 2019 оны 7 дугаар сард дэлхийд финтекийн үйл ажиллагаагаараа тэргүүлэх FIS болон олон улсын худалдааны үйлчилгээ үзүүлэгч Worldpay гэх компаниуд нэгдэж 42.5 тэрбум ам долларын хэлцэл хийсэн нь энэ оны эхний хагас жилийн нийт хэлцлийн дүнгээс ч их байгаа юм.

Зураг 1. Финтекийн салбарын хэлцлийн нийт дүн, тоо



Эх сурвалж: “Pulse of Fintech” KPMG, 2020

2019 оны болон 2020 оны эхний хагас жилийн байдлаар финтекийн салбарын нийт хэлцлийн бүтцийг зураг 2-т харуулвал:

Зураг 2. Нийт хэлцлийн бүтэц, тэрбум ам доллароор



Эх сурвалж: “Pulse of Fintech” KPMG, 2020

Энэ оны эхний хагас жилийн байдлаар хийгдсэн хамгийн их дүнтэй 10 хэлцлийн жагсаалтыг Индонез улсын Gojek компанийн төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээний салбарт хийсэн 3 тэрбум ам долларын хэлцэл тэргүүлсэн байна.

Хүснэгт 1. Хамгийн их дүнтэй 10 хэлцэл:

Нэр	Хэлцлийн дүн /ам.доллар/	Улс	Үйл ажиллагааны чиглэл
1. Gojek	3 тэрбум	Индонез	Төлбөр тооцоо
2. Open lending	1.3 тэрбум	АНУ	Зээл
3. Grab	886.0 сая	Сингапур	Төлбөр тооцоо
4. Stripe	850.0 сая	АНУ	B2B
5. RDC	700.0 сая	АНУ	Регтек
6. Chime	700.0 сая	АНУ	Банк
7. N26	570.0 сая	Герман	Банк
8. Revolut	500.0 сая	Их британи	Төлбөр тооцоо
9. Robinhood	430.3 сая	АНУ	Хөрөнгийн удирдлага
10. Navi Technologies	397.9 сая	Энэтхэг	Төлбөр тооцоо

Энэ удаагийн топ 10 компанийн дунд регтек компани орж ирснээр онцлогтой болсон ба 2020 оны эхний хагас жилийн байдлаар регтекийн салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 1.9 тэрбум ам.доллар ба нийт 89 удаагийн хөрөнгө оруулалтын хэлцлийг хийсэн байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад нийт хэлцлийн тоо буурсан хэдий ч хэлцлийн хэмжээний хувьд өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ өсөлт 2020 оны 2 дугаар хагас жилд ч хадгалагдана гэж таамаглаж байна. Үүнээс гадна санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль, дүрэм, журам зохицуулалтууд шинэчлэгдэж, өөрчлөгдсөөр байгаатай холбоотойгоор регтекийн компаниудын нөлөө улам нэмэгдэнэ гэж үзжээ.

Зураг 3. Регтек компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын дүн, тоо



Эх сурвалж: “Pulse of Fintech” KPMG, 2020

Улс орнуудын санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд регтекийн салбарыг дэмжих хандлага ажиглагдаж байгааг тус тоймд онцолжээ. Тухайлбал АНУ-ын таваарын фьючерсийн арилжааны комисс (CFTC)-оос регтек компаниудын өрсөлдөх чадвар, тэдгээрийн санал, шийдлийг дэмжих хүрээнд LabCFTC буюу инновацийн төв, лабораторийг үүсгэн байгуулжээ. Үүнээс гадна Арабын Нэгдсэн Эмират улсын санхүүгийн салбарын зохицуулагч болох ADGM-ийн хувьд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг “бот” буюу зөвхөн програм хангамж ашиглан шийдвэрлэж байна.


Мөн 2020 оны 2 дугаар хагас жилээс Европын холбооноос Их британи улс гарсны дараагаар буюу “post-Brexit” үеийн зохицуулалт, дүрэм журмын өөрчлөлттэй холбоотойгоор регтекийн хэрэгцээ шаардлага өсөх хандлагатай гэж тооцоолж байна.

KPMG-ээс гаргасан “Pulse of Fintech” 2020 оны эхний хагас жилийн тоймын эх хувийг дараах холбоосоор унших боломжтой.



СУДЛААЧИЙН ИНДЭР

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НОГООН БИЧИЛ САНХҮҮГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ БОЛОМЖ



Гантулгын Ивээл
Санхүүгийн зохицуулах хорооны
мэргэжилтэн

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар бичил санхүүгийн байгууллагын нэг болох банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдлыг хэмжихээр зорьсон. Судалгаанд банк бус санхүүгийн байгууллагын зах зээлийн 50 хувийг бүрдүүлэгч идэвхтэй 40 банк бус санхүүгийн байгууллагаас ногоон бичил санхүүг үнэлдэг загвар болох “Ногоон индекс 2.0” аргын 4 стандартын дагуу чанарын болон тоон судалгааг асуулга авах, ярилцлага хийх замаар авсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан 40 банк бус санхүүгийн байгууллагын ногоон бичил санхүүгийн өнөөгийн түвшин бусад улс орнуудын дундажтай ижил түвшинд сайн дурын хэрэгжилттэй байгаа ба томоохон банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд дотоод эрсдэлээ удирдах, стратеги бодлогоо тодорхойлохдоо сайн байгаа бол жижиг банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд харьцангуй сул байдал ажиглагдлаа. Гэвч бүх ББСБ-уудын хувьд гадаад эрсдэлээ удирдах байдал нийтлэг сул удирдлагатай байна.

Хамгийн чухал үзүүлэлт болох ногоон байдлыг дэмждэг байдлын хэрэгжилт нийтлэг сул байгаагаас гадна өөрсдийн ногоон санхүүжилтийн тоон үзүүлэлтүүдийг

бүртгэх, хянах болон санхүүгийн бус үйлчилгээг зээлдэгчдэдээ хүргэх чадвар сул. Ногоон бичил санхүүг хэрэгжүүлдэг болон хэрэгжүүлдэггүй ББСБ-уудыг харьцуулсан дүнгээс үзэхэд ногоон бичил санхүүг хэрэгжүүлсэн байгууллагуудад давуу тал бий болж байна.

СЭДВИЙН ҮНДЭСЛЭЛ

Орчин үед бичил санхүүгийн байгууллагуудад ядуурлыг бууруулах зорилгын зэрэгцээ тогтвортой байдлыг хангах томоохон чиглэл бий болжээ. Бичил санхүү нь үндсэндээ “эдийн засаг”-ийн хүрээний агуулга, асуудлыг хамаарч байсан бол сүүлийн жилүүдэд “нийгэм/social, эдийн засаг/economic, байгаль орчин/environment” буюу тогтвортой хөгжлийн хүрээний асуудалд анхаарах, түүнчлэн энэ хүрээнд нийгмийн өмнө хариуцлага хүлээх шаардлага тулгарах болсон. Банк, банк бус санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөр дамжуулан иргэд болон байгууллагуудад хүрч буй бичил зээлийн хэмжээ тасралтгүй өсөж байгаа нь нийгэмд бичил санхүүгийн нөлөөлөл өндөр байгааг илтгэнэ. Иймд зээлийн агуулга, зориулалтыг дээрх тогтвортой хөгжлийн хандлагад чиглүүлэх, дэмжих механизм хувь хүн төдийгүй улс орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна.

Бичил санхүү болон тогтвортой санхүүжилтийн асуудалтай холбоотойгоор “ногоон бичил санхүү” гэх ойлголт гарч ирсэн ба уг санхүүжилт нь тогтвортой хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах, цаг уурын нөлөөллийг багасгах, үр ашигт шинэлэг инноваци технологийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй бизнес, төслийг санхүүжүүлэхэд чухал хувь нэмэртэй. Олон улсад ногоон бичил санхүүг хэрэгжүүлэгч гол байгууллагыг бичил санхүүгийн байгууллага гэж нэрлэдэг бол манай орны хувьд бичил санхүүгийн байгууллага (ББ) гэх ойлголт банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодыг багтаан ойлгодог.

Хэдийгээр манай улсын хувьд тогтвортой ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэгч гол байгууллага нь санхүүгийн салбарын 95%-

ыг бүрдүүлэгч банкны салбар болоод байгаа ч сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод хөгжиж, тэдгээрийн нийт олгож буй зээлийн хэмжээ болон харилцагчдын тоо жил тутам хурдацтайгаар өсөж байна. Цаашид ч өсөх хандлагатай байгаагийн тод жишээ нь “Санхүүгийн зах зээлийг 2025 хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т банк бус санхүүгийн байгууллагуудын эдийн засагт гүйцэтгэх үүргийг 2 дахин нэмэгдүүлж, өрсөлдөх чадвар бүхий санхүүгийн зах зээлийн тогтолцоо бий болгоно гэж төрийн бодлого тодорхойлогч байгууллагуудын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсанаар илэрнэ. Тиймээс дан ганц банкны салбар бус банк бус санхүүгийн салбар ч байгаль орчны өмнө чухал хариуцлага хүлээн ажиллах болоод байна. Мөн 2017 оны “Тогтвортой санхүүжилт форум”-д тусгагдсанаар Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлогын хөтөлбөрт ногоон бичил санхүүг банк бус санхүүгийн салбарт нэвтрүүлнэ гэж тунхаглажээ.

Гэвч манай орны хувьд энэ томоохон зорилтын хүрээнд бичил санхүүгийн байгууллагуудын “ногоон бичил санхүү”-ийн өнөөгийн байдалд үнэлгээ шинжилгээ хараахан хийгдээгүй. Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын зарим банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах чиглэлийг судлан үзэхээр зорьсон. Тухайн байгууллагын олгож буй бичил зээл нь байгаль орчин, хүрээлэн буй орчны асуудлыг шийдвэрлэхэд чиглэж дэмждэг эсэх, мөн тухайн ББСБ нь өөрөө нийгмийн өмнө байгаль орчноо хайрлан хамгаалах үүргээ хэрхэн хэрэгжүүлдэг байдлыг судлав. Тиймээс ногоон эдийн засаг, ногоон санхүүжилтэд бичил санхүүгийн байгууллагуудын оролцоог тодорхойлж, тэр дундаа банк бус санхүүгийн байгууллагын ногоон бичил санхүү, байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх нь энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго болно.

СЭДВИЙН СУДАЛГАДСАН БАЙДАЛ

(Allet. M. 'Measuring the environmental performance of microfinance: a new tool', 'Green Microfinance: Characteristics of Microfinance Institutions Involved in Environmental Management', 'Why do microfinance institutions go green?') судалгаагаар нэг түүвэр дээр үндэслэн 2007–2015 онуудын хооронд хийсэн олон улсын 160 бичил санхүүгийн байгууллагатай хамтран тэдгээрийн онцлог шинж чанарыг тодорхойлох, орчны гүйцэтгэлийн үнэлгээний шинэ загвар болох MEPI-г ажиллуулан үнэлэх, менежерүүдтэй ярилцлага хийх замаар яагаад бичил санхүүгийн байгууллагууд ногоон санхүүжилтийн тогтолцоо руу шилжиж буйг судлажээ.

(Armonia Pierantozzi, 2015) судалгаанд хамгийн багадаа нэг төрлийн байгаль орчны практикийг хэрэгжүүлдэг 204 ББСБ оролцсон. Байгаль орчны гүйцэтгэлийг үнэлдэг Green Index болон МИКС гэх 2 төрлийн үнэлгээний аргын хоорондоо ойролцоо 5 шалгуур үзүүлэлтийг сонгож асуулга боловсруулан судалгаагаа хийсэн. Судалгааны үр дүнд үзүүлэлтүүдийн ашигт байдал болон ББСБ-уудын хянах чадварын хоорондын зөрүүг олж тогтоосон байна.

(European Microfinance Platform, 2015) судалгаанд 87 бичил санхүүгийн байгууллага оролцсон ба тэдгээрийн байгаль орчны чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүдийг үнэлсэн. Үр дүнд шалгуур үзүүлэлтүүдийг хянах чадвар болон шийдвэр гаргалтад хэрэгтэй байдал хоёрын хооронд чухал ялгаа илэрсэн. ББСБ-ууд ногоон санхүүгийн ах холбогдлыг бүрэн ойлгоогүй нь байгаль орчны гүйцэтгэлээ үнэлэхэд саад болж байгаа тухай дүгнэлтэд хүрчээ.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ

Олон улсын судлаачдын бичил санхүүгийн байгууллагуудын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлсэн жишиг судалгааны ажлууд байдаг ч Монгол Улсын нөхцөлд тохируулж хийгдсэн судалгааны ажил байдаггүй. 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”, “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөр”-ийг баталж, 2017 оны “Тогтвортой санхүүжилт форум”-аар банк бус санхүүгийн байгууллагуудыг хамруулж ногоон бичил санхүүг дэмжин ажиллуулахаар тусгасан боловч 3 жил хугацаанд хэрэгжилтийн түвшинг тооцож гаргасан үнэлгээ дүгнэлт дутагдаж байна. Иймд энэхүү судалгааны ажлаар өөрийн орны ББСБ-уудын байгаль орчны гүйцэтгэлийг үнэлж, санал дэвшүүлээ.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Европын бичил санхүүгийн платформ (e-MFP) нь 2014 онд бичил санхүүгийн байгууллагын байгаль орчны үр дүнг үнэлэх практик хэрэгсэл болох Ногоон индексийг боловсруулсан бөгөөд үүнээс 2 жилийн дараа уг индексийг шинэчилж, илүү боловсронгуй болгож “Ногоон индекс 2.0”-ыг гаргаж ирсэн. Ногоон индекс нь ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдлыг хэмжих, байгаль орчны үнэлгээ хийх, байгаль орчны менежментийг дэмжих зорилготой. Ногоон бичил санхүүгийн үйлчилгээг байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлэх, ногоон бичил санхүүгийн талаар харилцагчдадаа мэдлэг, мэдээлэл өгөх, дэмжлэг үзүүлэх болон тухайн санхүүгийн байгууллага өөрийн дотооддоо экологийн үл мөрийг бууруулах зэргээр хэрэгжүүлдэг бөгөөд олон улсад тус хэрэгжилтийг үнэлдэг олон аргачлалуудаас “Ногоон индекс 2.0” буюу 4 стандартыг сонгон судалгаандаа ашигласан. Уг индексийг 0–5 оноогоор хэмжих ба

хэмжээст оноо өндөр гарах нь ногоон бичил санхүү сайн түвшинд хэрэгжиж байгааг илтгэнэ.

Судалгааны түүвэр: Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан банк бус санхүүгийн салбарын 50 хувийг бүрдүүлэгч, идэвхтэй 40 ББСБ-ыг түүвэрлэн сонгосон болно. 40 ББСБ-аа харилцагчдын тоо, зорилтот бүсчлэлээр нь харьцуулж үзэв.

- 3000-аас доош идэвхтэй зээлдэгчтэй ББСБ-ыг жижиг, 3000–30000 бол дунд, 30000-аас дээш бол том гэж ангилав. Судалгаанд хамрагдсан эдгээр 40 ББСБ-ийн 2 нь 100,000-аас дээш зээлдэгчтэй байсан бол 11 нь 3,000–10,000 хүртэл зээлдэгчтэй байв (график 1).
- Эдгээр байгууллагуудын 60% нь зорилтот бүсчлэлээ Улаанбаатар хот гэж тодорхойлсон бол үлдсэн хувь нь холимог гэж тодорхойлжээ (График 2).

График 1. Харилцагчдын тоогоор






График 2. Зорилтот бүсчлэл



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дундаж оноо нь байгаль орчны гүйцэтгэлийн удирдлагын дөрвөн стандарт тус бүрийн авсан онооны дундажийг илэрхийлнэ. Зарим стандарт нь бусдаасаа илүү олон шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан (1 болон 4 дүгээр стандарт хамгийн олон үзүүлэлттэй) бол зарим нь хэмжихэд илүү хялбар байв. Дундаж оноог хэмжээс бүрд гаргаж ирснээр тэдгээрийн давуу болон сул тал, сайжруулах гарцыг тодорхойлох боломжтой бүрдэнэ.

График 3. МИКС Маркет /судалгааны 40 ББСБ харьцуулалт/




Судалгаанд оролцсон 40 байгууллагын 4 стандартын дундаж хэмжээт оноо дээрх байдлаар харагдаж байна. Үзүүлэлтүүдээс байгаль орчны гадаад эрсдэлийг удирддаг байдал хамгийн бага хэмжээт оноо (1.44) авчээ. Үүнд байгаль орчны эрсдэлийг үнэлдэг тусгай арга хэрэгсэл, зээлийн ажилтантай байдал мөн ирсэн зээлийн өргөдлийн эрсдэлийг үнэлж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байдал багтана. Төв болон салбар байрны ус, цахилгааны, хог хаягдлын гарцыг байнга хянаж, хэрэглээг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн экологийн ул мөрөө удирддаг байдал хамгийн өндөр оноо (2.5) авсан. Гэвч экологийн ул мөрийг хэмжих үзүүлэлтүүд нь БСБ-ийн зөвхөн байгальд үзүүлэх шууд нөлөөллийг хэмждэг ба эдгээр нөлөөлөл нь тэдний байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн маш бага хувийг эзэлнэ.

Байгаль орчны стратегия тодорхойлох нь стандарт 3 болон 4-ийн хэрэгжилтийн үндэс болдог бөгөөд стандарт 1-ын оноо бага байх нь тус 2 стандартын оноонд нөлөөлнө.

Үүнээс дүгнэхэд МИКС Маркетаас хийсэн дэлхийн бүсүүдийн дундажтай харьцуулвал манай судалгаанд хамрагдсан БСБ-уудын ногоон бичил санхүүгийн хэрэгжилт улс орнуудын дундажтай ойролцоо түвшинд харагдаж байна. Байгууллагын хэмжээ тус бүрээр стандартуудын дундаж оноо дараах байдалтай байна /График 4/.

График 4. Байгууллагын хэмжээгээр дундаж оноо



Томоохон байгууллагууд ерөнхийдөө бүх стандартуудын хувьд давуу гүйцэтгэлтэй байна. Ялангуяа хүрээлэн буй орчны дотоод эрсдэлээ удирдахад 5-аас 4 оноо авсан нь салбарууд ихсэж, үйл ажиллагааны цар хүрээ өргөжих тусам гарч буй хэрэглээ, зардлын хэмжээгээ бууруулахын тулд тавих хяналтаа улам чангатгадагтай холбогдож болох юм. Мөн стратеги бодлогоо тодорхойлдог байдал (3.5 оноо) бусдаасаа сайн байгаа бол жижиг байгууллагуудын хувьд харьцангуй сул (1.58) байдал ажиглагдав. Бүх нэгжүүдийн хувьд гадаад эрсдэлээ удирдах байдал сул (1.44 оноо) удирдлагатай байна. Хамгийн чухал үзүүлэлт болох ногоон боломжийг дэмждэг байдал бүх хэмжээний байгууллагын хувьд дутмаг байна.

(Аллет ба Худон, 2013)-ны 23 судалгаанд байгууллагын насжилт, хэмжээ нь их байх тусам ногоон зээл болон санхүүгийн бус үйлчилгээг санал болгох хандлагатай байдаг гэсэн үр дүнд хүрсэн нь энэхүү судалгаанаас мөн адил харагдаж байна.

График 5. Үйл ажиллагааны зорилтот бүсчлэлээр



Зорилтот бүсчлэлийн дундаж оноог харахад зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа төвлөрүүлсэн БСБ-уудын хувьд хөдөө орон нутагт чиглэсэн БСБ-уудыг бодвол ногоон бичил санхүүгийн

гүйцэтгэл муу байна. Санхүүгийн нөөц боломж хязгаарлагдмал, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй бичил санхүүгийн зорилтот хэрэглэгчид ихэвчлэн хөдөө орон нутагт төвлөрсөн байдаг тул уг бүсчлэлд чиглэсэн БСБ-уудын бичил ногоон санхүүгийн гүйцэтгэл өндөр гэж таамаглалаа.

График 6. Ногоон бичил санхүүг хэрэгжүүлдэг байгууллагуудын дундаж оноо



Стандарт 1-ыг нийт 40 байгууллагаас 32 нь хэрэгжүүлдэг бөгөөд үзүүлэлтүүдийн дундаж оноо 2.04 гарчээ. Энэ нь хэрэгжүүлэгч байгууллагуудын хувьд хамгийн бага оноо авсан стандарт юм. Стандарт 2-ыг мөн 32 байгууллага хэрэгжүүлдэг ба бусад стандартуудаас хамгийн өндөр оноотой байна. Дотооддоо экологийн ул мөрөө бууруулах ажлыг байгууллага ногоон бичил санхүүгийн хэрэгжилттэй холбоогүйгээр тогтмол зардлаа хянаж, бууруулах зорилгоор хэрэгжүүлж байж болох талтай.

Судалгаанд оролцсон 40 БСБ-ын дундаж оноо болон ногоон боломжийг дэмждэг 21 БСБ-ын дундаж оноог харьцуулан үзэхэд 40 байгууллагын хүрээнд өгсөн өөрийн үнэлгээгээр 1.7 оноотой байсан бол 21 байгууллагын хүрээнд 2.8 оноо болж өсжээ. Ногоон бичил зээл, даатгуулахыг санал болгодог, зээлдэгчдэд зориулж сургалт явуулдаг БСБ-уудын тоо харьцангуй цөөн байгаа ч тухайн үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээ өндрөөс шалтгаалсан. Уг стандартын оноо өндөр байх нь БСБ-ууд байгаль орчинд бодитоор нөлөөлж чадаж байгааг илтгэх буюу БСБ-уудын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн 99.9%-ыг уг стандарт тайлбарлана. Одоогийн байдлаар ногоон бичил зээлийг хэрэгжүүлж эхлээгүй байгаа байгууллагууд хэрэгжүүлж эхэлбэл өөрсдийн зээлийн багцыг нэмэгдүүлэх, зээлийн бүтээгдэхүүнээ төрөлжүүлэхээс гадна байгаль орчны гүйцэтгэлд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

ДҮГНЭЛТ

Бичил санхүүгийн байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа нь үндсэндээ “эдийн засаг”-ийн хүрээний агуулга, асуудлыг хамарч байсан бол сүүлийн жилүүдэд “нийгэм, эдийн засаг, байгаль орчин” буюу тогтвортой хөгжлийн хандлагад чиглэх болж түүнийг дэмжих механизм бүрэлдэж эхэлсэн байна. Ногоон бичил санхүүг байгаль орчны гүйцэтгэлийн “Ногоон индекс 2.0” загвар буюу “Байгаль орчны стратегия тодорхойлох, хяналт тавьдаг, хүрээлэн буй орчны дотоод болон гадаад эрсдэлээ удирддаг, ногоон боломжийг дэмждэг” гэсэн 4 стандартаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан банк бус санхүүгийн салбарын 50 хувийг бүрдүүлэгч, идэвхтэй 40 БСБ-уудын хувьд үнэлж үзэхэд дараах үр дүн гарав:

МИКС Маркетаас гаргасан дэлхийн тивүүдийн бичил санхүүгийн байгууллагуудыг “Ногоон индекс 2.0”-оор тооцсон судалгаатай жиших замаар харьцуулахад +/- 0.16 онооны зөрүүтэй гарснаас дүгнэхэд БСБ-ууд байгаль орчны өмнө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлаж бичил ногоон санхүүг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн, мөн зүйлчилж өгсөн хууль, тогтоомж байхгүйгээс харахад сайн дурын хэрэгжилттэй байна.

Харьцангуй том хэмжээтэй банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд дотоод эрсдэлээ удирдах (4 оноо), стратеги бодлогоо тодорхойлох (3.5 оноо) зэрэгт бусдаасаа сайн байгаа бол жижиг байгууллагуудын хувьд харьцангуй сул (1.65;1.58) байдал ажиглагдав. Гэвч бүх нэгжүүдийн хувьд гадаад эрсдэлээ удирдах байдал сул (1.44 оноо) удирдлагатай байна.

Үйл ажиллагааны цар хүрээ өсөх тусам байгаль орчинд нөлөөлөх байдал ихсэж, үүнийгээ дагаад илүү байгаль орчны өмнө хүлээж буй үүрэг хариуцлагаа ухамсарлан, тогтсон зорилго, бодлого, стратегитай ажиллаж эхэлдэг. Стандарт 1–ыг том байгууллагууд ихэвчлэн өндөр үнэлгээтэй хэрэгжүүлж байна.

Холимог бүсчлэлд үйл ажиллагаа явуулдаг ББСБ–уудын ногоон бичил санхүүг хэрэгжүүлэх байдал зөвхөн хотод бүсчлэлээ тогтоосон ББСБ–уудыг бодвол 0.25–06 оноогоор өндөр байна. Ногоон боломжийг дэмждэг байдал хамгийн их онооны зөрүүтэй байна.

Санхүүгийн байгууллагуудын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн 99.9 хувь нь санхүүжүүлсэн үйл ажиллагаагаар нь дамжин шууд бусаар илэрдэг бол энэхүү хамгийн чухал стандарт болох ногоон боломжийг дэмждэг байдлын үзүүлэлт хангалттай сайн байж чадахгүй буюу 1.7 оноогоор үнэлэгдэжээ. Холимог бүсчлэлд 1.97 оноогоор үнэлэгдсэн.

Стандартыг хэрэгжүүлэгч байгууллагуудын өөрт өгсөн дундаж үнэлгээ 2–3.1 онооны хооронд байна. Хэдий байгаль орчинд ээлтэй байж, ногоон бичил санхүүг хэрэгжүүлэхийг зорьж байгаа ч хэрэгжилт хангалттай түвшинд хүрэхгүй байгааг харж болно. Нэг талаар хэрэгжилтээ 5 оноонд хүргэж чадахгүй нь сул талтай ч нөгөө талаар цаашид ногоон бичил санхүүг илүү сайн хөгжүүлж, илүү олон ББСБ үйл ажиллагаагаа байгаль орчинд ээлтэй болгон сайжруулах боломж ажиглагдлаа.

4 стандартаас аль нэг стандартын дундаж 0–тэй ойролцоо буюу орхигдсон гараагүй нь банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд ногоон бичил санхүүг хэрэгжүүлэх олон төрлийн арга ашиглаж байгааг илтгэнэ.

Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэн үзвэл: Ногоон бичил санхүүг хэрэгжүүлж буй ББСБ–уудын үзүүлэлтээс харвал судалгаанд хамрагдсан бусад ББСБ–ууд үүнийг хэрэгжүүлбэл ногоон бичил санхүү нь манай орны хувьд улам дээшлэх бүрэн боломж байгааг илтгэнэ. Ногоон бичил санхүүг хэрэгжүүлснээр ББСБ–уудад дараах боломжууд бий болж байна.

- Хөрөнгийн эх үүсвэр татах өртөг багасна;
- Ашигт зэрэгээр нөлөөлнө;
- Байгууллагын нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага дээшилж, нэр хүнд өснө;
- Шинэ зах зээл, шинэ харилцагч нэмэгдэнэ;
- Ногоон зээлийн туршлага, чадавхтай болно.

НОГООН БИЧИЛ САНХҮҮ ББСБ–Д ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Ногоон бичил санхүү ББСБ–д хэрхэн нөлөөлдгийг судлах зорилгоор судалгаанд оролцсон ББСБ–уудаас түүвэрлэн 5 байгууллагын санхүүгийн ажилтантай ярилцлага хийв. Судалгаанд хамрагдсан ББСБ–ын ихэнх хувь нь компанийн санхүүгийн үзүүлэлтийг олон нийтэд мэдээлдэггүй учир уг судалгааны аргыг ашиглав. Ярилцлагаас дараах нийтлэг үр дүнгүүд ажиглагдлаа:

1. Эх үүсвэрийн хямд өртөг: Хөрөнгө оруулагчид хамгийн багадаа банкны хадгаламжийн хүүтэй тэнцүү эсвэл түүнээс өндөр

хэмжээний өгөөжийг оруулсан хөрөнгө оруулалтаасаа шаарддаг. Тухайлбал ойролцоогоор хадгаламжийн хүү 14% бол 16%–ын өгөөж ББСБ–аас шаарддаг. Харин ногоон бичил санхүү хэрэгжүүлж буй тохиолдолд гаднын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулагчдаас хамгийн ихдээ 5–6%–ын хүүтэй санхүүжилт босгох боломж олддог.

2. Зардал буурснаар ашиг өсөх боломжтой: Хэдийгээр эх үүсвэрийн хямд өртөг татсан ч олгож буй зээлийн хүүг огцом бууруулдаггүй. Бусад эх үүсвэрээс татсан хөрөнгөөр олгосон зээлийн хүү сарын 1.5% орчим байдаг бол хямд өртгөөр татсан эх үүсвэрээр ногоон зээлээ санхүүжүүлэхдээ зээлийн хүүгээ 1.2% болгож бууруулдаг. Байгууллагын үйл ажиллагааны зардал тогтмол 4%–тай байхад ББСБ–аас гарах нийт зардлын хэмжээ 9%, зээлдэгчдээс орж ирэх хүүний хэмжээ 14.4% бөгөөд энэ хоёрын зөрүү 5.4% ашиг болдог байна.
3. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага сайжирч, нэр хүнд өснө: ББСБ–ууд ногоон бичил санхүүг нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх нь их. Нийгмийн хариуцлага сайтай байгууллагын нэр хүнд дагаад өсдөг. Ингэснээр харилцагчид олширч, өрсөлдөх чадвар нэмэгдэж, үйл ажиллагаа сайжрахад нөлөөлдөг. Мөн байгууллагыг нийгэмд сурталчлах, PR хийх нэг хүчин зүйл юм.
4. Шинэ зах зээл дээрх харилцагчид бий болно: Хэрэглээний зээл, автомашины зээл олгодог байсан бол ХАА, газар тариалангийн зээлийн шинэ бүтээгдэхүүн санал болгосноор бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж, шинэ зах зээлд үйл ажиллагаагаа явуулах, олон харилцагчтай болох давуу талтай.
5. Ногоон зээлийн туршлага, чадавхтай болно: Ногоон зээл олгох шинэ туршлагатай болж байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтан томилох, зээлийн ажилтнаа сургах зэргээр хүний нөөцийн чадавх дээшилдэг.

2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ОЛГОЖ БУЙ НОГООН БИЧИЛ САНХҮҮГ НЭМЭГДҮҮЛЭХ, САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

Дээрх судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах зөвлөмжүүдийг дэвшүүлж байна:

- Ногоон боломжийг дэмжих буюу стандарт 4–ыг хэрэгжүүлэх: Банк бус санхүүгийн байгууллагын байгаль орчин дахь нөлөөллийн 99.9% нь санхүүжүүлж буй үйл ажиллагаагаар дамжин шууд бусаар илэрдэг. Судалгаанд оролцсон байгууллагуудын ногоон боломжийг дэмждэг байдал буюу ногоон санхүүжилт олгох, харилцагчдад энэ чиглэлээр сургалт зохион байгуулах үйл ажиллагааны дундаж үнэлгээ 1.7 буюу хангалтгүй гарсан.
- Бодлого зохицуулалт, эрх зүйн орчныг бий болгох: Ногоон санхүүжилтийг төрөөс дэмжиж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, хууль зүйн зохицуулалт бий болгох нь бичил санхүүгийн байгууллагуудын ногоон бичил санхүүжилтийн түвшинг нэмэгдүүлэхэд тусална.
- Ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, төсөл боловсруулах: Манай улсад Хас банк ногоон бичил санхүүг төслөөр дамжуулан 2009–2012 онд амжилттай хэрэгжүүлж байсан. Уг ажлын хүрээнд олон айл өрх дулааны асуудлаа шийдэж, нүүрсний хэрэглээгээ багасгаж чаджээ. Мөн банк бус санхүүгийн байгууллагууд ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлж, төсөл боловсруулснаар гаднаас бага өртөгтэй хөрөнгө

оруулалт татах, илүү өргөн хүрээнд зээлдэгчдэд хүрч ажиллах боломжтой байдгийг ярилцлагын үр дүнд илрүүлсэн. Тиймээс ББСБ-ууд ногоон бичил санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлж, төсөл боловсруулан ажилласнаар зээлдэгчдийн төрөлжилт нэмэгдэн, илүү олон харилцагчтай болж ногоон бичил санхүүжилтийн хэмжээг ихэсгэх боломжтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. М. Аллет ба М. Худон (2013). Ногоон бичил санхүү– Байгаль орчны менежментэд оролцдог бичил санхүүгийн байгууллагын шинж чанар. Бизнесийн ёс зүйн сэтгүүл.
2. М. Аллет. (2013). Яагаад бичил санхүүгийн байгууллагууд ногоон болж байна вэ?. Бизнесийн ёс зүйн сэтгүүл.
3. М. Аллет. (2012). Бичил санхүүгийн санхүүжилтийн байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих шинэ хэрэгсэл.
4. Бичил санхүүгийн уулзалт. (2015). Бичил санхүү гэж юу вэ?. Гарын авлага, 2–3
5. С. Дашдорж, Д. Оюунцэцэг нар. (2019). ‘Тогтвортой санхүү’. Бичил санхүү ба тогтвортой санхүүжилт, 335–353
6. Дэлхийн банк. (2012). Санхүүгийн салбарын үнэлгээний хөтөлбөр. Теникийн тэмдэглэл, 5–7
7. Дэлхийн банк. (2015). Бичил санхүү– Тойм судалгаа. IEG ажлын баримт, 1–2.
8. Европын Бичил Санхүүгийн Платформ. (2015). Ногоон бичил санхүү– Байгаль орчны гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлтүүдийг үнэлэх.
9. Европын Бичил Санхүүгийн Платформ. (2018). Ногоон хүртээмжтэй санхүү ба цаг уурын ухаалаг санхүү. Ногоон индекс сургалт, 8–10
10. Европын Бичил Санхүүгийн Платформ. (2016). Ногоон Индекс 2.0– Бичил санхүүгийн салбарт байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх шинэлэг хэрэгсэл. Товхимол, 1–5
11. Европын Бичил Санхүүгийн Платформ. (2014). Хөдөө аж ахуй ба Ногоон бичил санхүү.
12. Интер–Америкийн Хөгжлийн Банк. (2017). Латин Америк ба Карибын ногоон бичил санхүү. 14
13. МИКС маркет. (2018). Глобал байдал ба санхүүгийн үр дүнгийн үнэлгээний тайлан. 18–19
14. Монголын банкны холбоо. (2013). Тогтвортой санхүүжилт хөтөлбөр.
15. Монголын Банкны холбоо. (2016). Монгол улсын ногоон зах зээлийн судалгаа. 168–170
16. Нэгдсэн Улсын Хөгжлийн Хөтөлбөр. (2011). Байгууллагын өөрчлөлт – Хасбанкны түүх. 2–5
17. Олон Улсын Санхүүгийн Корпорац. (2019). Бичил санхүүгийн товхимол. 4
18. Олон улсын санхүүгийн корпорац. (2009). Бичил санхүү болон санхүүгийн салбарын судалгаа. 38–39
19. М. Оюунгэрэл. (2019). Тогтвортой санхүү.
20. Өөрийн садалгаа. (2020). Банк бус санхүүгийн байгууллагын ногоон бичил санхүүгийн өнөөгийн байдал, сайжруулах боломж.
21. А. Рамасвами (2016). Бичил санхүү ба тогтвортой хөгжлийн хоорондох холбоо. Европын тогтвортой хөгжлийн сэтгүүл, 453–460
22. Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Банкнаас бусад санхүүгийн салбарын тойм 2019. 27–30
23. Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Банкнаас бусад санхүүгийн салбарын тойм 2019. 64–67,74–77
24. Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Зах зээлийн тойм. Хүртээмжтэй санхүү сэтгүүл, 10, 24–26
25. Санхүүгийн Зохицуулах Хороо. (2019). Санхүүгийн салбарын 2019 тойм.
26. Санхүүгийн зохицуулах хороо. (2019). Банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга. 9–10
27. Д. Форселла. (2013). Европын ногоон бичил санхүү. EMN судалгааны баримт бичиг



ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО



ТАНИЛЦУУЛГА: Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо /МХЗХҮХ/ нь 1998 онд 9 ХЗХ-ны санаачилгаар байгуулагдсан. Хадгаламж,

зээлийн хоршооны тухай хуулийн дагуу 2012 онд “Үндэсний” статустай болсон бөгөөд 178 гишүүн хадгаламж, зээлийн хоршоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.


АЛСЫН ХАРАА: Мэргэжлийн санхүүгийн үнэ цэнэтэй байгууллагыг хамтдаа бүтээлцэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Хадгаламж, зээлийн хоршоодын хөдөлгөөний нэгдмэл байдлыг үндэсний хэмжээнд төлөөлж, гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино.

ҮНЭТ ЗҮЙЛС:

- Хоршооллын зарчим
- Мэргэжлийн байгууллага
- Хариуцлага
- Чадварлаг хамт олон

МХЗХҮХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:



ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА: МХЗХҮХ нь төр засгийн болон бусад байгууллагын өмнө хадгаламж, зээлийн хоршоодыг төлөөлөн нийтлэг эрх, ашиг сонирхлыг хамгаалж, төрөөс тодорхойлсон бодлогын талаар санал дүгнэлт гаргах, зах зээлийн нэгдмэл байдлыг хангаж, гадаад ба дотоодын байгууллага, холбоодтой холбоо тогтоож ажилладаг.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /МОССУ/, Канадын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /GVCCU/, Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/, Солонгосын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /NACUFOK/ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дотоод харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- МХЗХҮХ нь мэргэжлийн холбоодтой хамтран 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 102 ХЗХ-г хамруулсан хоршоо хөгжлийн үнэлгээг хийсэн.
- Дэлхийн байгаль хамгаалах сангийн “Ирвэстэй нутгийн ирээдүй” төслийн хүрээнд баруун бүсийн ХЗХ-дын санхүүгийн болон үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр 2 дахь жилдээ ажиллаж байна.
- Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Ногоон алт, малын эрүүл мэнд” төслийн үйл ажиллагаа явуулж байгаа сумдын малчдын ХЗХ-г дэмжих зорилгоор 2020 оны 10 дугаар сард баруун бүсийн хоршоодод сургалт, мониторинг хийхээр бэлтгэсэн.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООТой ХАМТРАН АЖИЛЛАХ ХҮРЭЭНД:

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ын 2.1.12-т заасан ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд МХЗХҮХ-ны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагын дагуу ХЗХ-дын гүйцэтгэх удирдлага, сонгуульт гишүүдийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж байгаа ба 2020 онд 252 сонгуульт гишүүн, гүйцэтгэх албаны удирдлагыг хамруулсан.

СЗХ, Банк санхүүгийн академитай хамтран ХЗХ-дод зориулсан комплаенс болон ёс зүйн стандартыг таниулах, зөв хандлагыг бий болгох, ажлын байранд гардаг нийтлэг алдаанаас сэргийлэх зорилготой цахим сургалтыг зохион байгуулж 153 ажилтныг хамруулсан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор СЗХ-ноос санхүүгийн салбарын нийт холбоодын ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх, цаашид сургагч багшаар ажиллахад шаардагдах суурь ур чадвар олгох, мэргэжлийн ахисан түвшний мэдлэгийг олгох сургалтад холбооны 7 сургагч багш бэлтгэгдсэн.

БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ:

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах СЗХ-ны ажлын хэсэгт МХЗХҮХ-ны төлөөлөл оролцож ХЗХ-дын саналыг нэгтгэсэн.


Хуулийн этгээдийн улсын бүртгэлд эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2020 онд багтаан бүртгүүлэх ажлын хүрээнд ХЗХ нь бусад хуулийн этгээдээс ялгаатайг харгалзан үзэх, ХЗХ-ны онцлогт тохируулан бүртгэлийг хийлгэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ӨРГӨН ДУРАН


ХОРОО ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮСИЙН САНААЧИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН ДЭД ДАРГААР СОНГОГДЛОО

ДЭЛХИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ ДИЖИТАЛ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ-КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ



CONGRATULATIONS!!!

Opening Remarks - AFI



Dr. Alfred Hannig
Executive Director - Alliance for Financial Inclusion

Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилгын зөвлөл /ECAPI–Eastern Europe & Central Asia Policy Initiative/–ийн ээлжит хурал энэ сарын 14–15–ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулагдлаа.

Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөлөөс “Хадгаламж, зээлийн хоршоодыг дижитал хэлбэрт шилжүүлэхэд гарах кибер аюулгүй байдлын эрсдэл” сэдвийн дор энэ сарын 08–нд цахим хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Цахим хэлэлцүүлэгт 6 тивийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагч байгууллагын 71 төлөөлөгч оролцсон юм.

Энэ удаагийн хурлаар зөвлөлийн гишүүн орнуудын 100 хувийн саналаар Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороог дэд даргаар сонгож томилсон. Хороог төлөөлж Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар цаашдын хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх, бүс нутгийн хүрээнд санхүүгийн хүртээмжийн бодлого стратегид тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахаа онцлон тэмдэглэлээ.

Дэлхий дахинд цар тахлын улмаас үүссэн хямралын үед хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн аюулгүй байдлыг хадгалах зорилгоор Үндэсний хадгаламж, зээлийн хоршоодын холбооны нөөц ба өргөжилтийг хариуцсан захирал Марта Ниничук, Канадын Санхүүгийн зах зээлийн зохицуулагчдын газрын Технологийн хянан шалгах газрын шинжээч Аяз Мамодали, Ирландын Төв банкны удирдах ажилтан, Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөлийн дарга Элайн Байрни нар хэлэлцүүлэгт илтгэл тавьсан юм. Мөн жижиг хадгаламж, зээлийн хоршоодыг дижитал хэлбэрт шилжүүлэх хэрэгцээ шаардлага ба хянан шалгагчдын оролцоо, дэмжлэгийн талаар, хянан шалгагчдын цахим сонор сэрэмжийг хэрхэн нэмэгдүүлэх түүнчлэн тус байгууллагын жил бүр болдог хуралд тавигдах Ковид–19–тэй холбоотой хязгаарлалт, шинэ арга замуудын тухай мэдээлэл өглөө.

Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачлагын зөвлөл нь бүс нутгийн хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой байгуулагдсан бөгөөд Монгол, Орос, Армени, Таджикстан, Беларусь, Казахстан, Узбекистан зэрэг орны холбогдох 7 байгууллага гишүүн нь юм.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ТУРШЛАГА СОЛИЛЦОНО

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /Alliance for Financial Inclusion/–ийн Жилийн тайлангийн хурал энэ сарын 09–нд цахим орчинд боллоо. Энэ удаагийн хурлаар 2020–2023 оны стратеги төлөвлөгөө, 2019 оны аудитын тайлан, коронавируст халдварын улмаас үүссэн нөхцөл байдлыг даван туулах арга зам, туршлагын талаар хэлэлцэв. Мөн чадавхийг бэхжүүлэх стратеги, санхүүгийн хүртээмжийг

WG MANAGEMENT UPDATE - WG Leaders

	CONSUMER EXPERIENCE AND INVESTOR RELATIONS CENTRAL BANK OF ZAMBIA	DIGITAL FINANCIAL SERVICES AFI FINANCIAL GROUP	FINANCIAL INCLUSION AND FINANCIAL LITERACY AFI FINANCIAL GROUP	FINANCIAL INCLUSION CENTRAL BANK OF TANZANIA	GLOBAL FINANCIAL INTEGRATION AFI FINANCIAL GROUP	INCLUSIVE GROWTH AFI FINANCIAL GROUP	ONE FINANCIAL GROUP AFI FINANCIAL GROUP
CHAIR	 Ms. Rochelle Tomas Banco Central ng Pilipinas	 Vacant Position	 Mrs. Marwa A. Elborsary Central Bank of Egypt	 Ms. Nangi Maswae Bank of Tanzania	 Ms. Caroline Pickering Reserve Bank of Fiji	 Mr. Walid Ali Central Bank of Egypt	 Mr. Markolo Bayani Bank of Zambia
CO-CHAIR 1	 Mrs. Marie-Josée Ndaya Central Bank of Congo	 Ms. Nadezhda Prazolova Central Bank of the Russian Federation	 Mr. Alex Ochan Bank of Uganda	 Ms. Noncebo Madibe Ministry of Finance of Eswatini	 Mr. Sayed Mohsin Sadaat De Afghanistan Bank	 Mr. Audrey Hove Reserve Bank of Zimbabwe	 Mr. Jason Barantes SUGUJ, Costa Rica
CO-CHAIR 2	 Mr. Moses Mwaanga Bank of Zambia	 Mr. Ehab Hoss Central Bank of Egypt	 Ms. Akata Taito Reserve Bank of Fiji	 Mr. Mackay Aomus Bank of Uganda	 Ms. Sally Abdel Kader Central Bank of Egypt	 Vacant Position	

нэмэгдүүлэх, дижитал санхүүгийн үйлчилгээг хүргэхэд хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлогыг тус, тус хэлэлцэж баталлаа.

Ингэснээр нийгэмлэгийн гишүүн орнуудад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрхийг хамгаалах стратеги боловсруулахдаа хэрэгцээ, шаардлага, онцлогтоо тохирсон арга, аргачлалаас суралцах, харилцан туршлага судлах боломж бүрдэж байгаа юм. Хуралд Санхүүгийн зохицуулах хорооны ажлын хэсэг, Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачлагын гишүүдийг ахлан Хорооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар оролцсон юм.

Нийгэмлэг нь дэлхийн хөгжиж буй 89 орны 100 төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагын гишүүнчлэлтэй, дэлхийн бичил санхүүгийн зах зээлийн 85 хувийг хамарсан, хүн амын ядуу буурай хэсэгт санхүүгийн үйлчилгээг ойртуулах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага. Жил бүр Дэлхийн бодлогын форумыг зохион байгуулж


санхүүгийн үйлчилгээг илүү нээлттэй, хүртээмжтэй болгоход чиглэсэн бодлогын шийдлүүдийг зөвшилцөн баталж, үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжлийг хурдасгахад гишүүн байгууллагууд хамтран ажилладаг.

Санхүүгийн зохицуулах хороо 2010 онд нийгэмлэгт гишүүнээр элссэнээс хойш Монгол Улсын санхүүгийн салбарын бодлого, мэдээллийг тунхаглалд тусгуулж, хамтран ажиллаж ирсэн. 2011 онд “Цахим мөнгөний зохицуулалт”, 2015 онд “ХАА-н гаралтай бараа түүхий эдийн зах зээлийн хөгжил”, 2017 онд “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа”, 2019 онд “Хүртээмжтэй ногоон санхүү” гэсэн мэдлэг солилцох 4 төслийг хэрэгжүүлэх судалгаа хийж, нийгэмлэгийн захирлуудын зөвлөлд сонгогдож, ажлын долоон хэсэгт оролцох зэргээр өргөн хүрээнд хамтран ажилладаг.



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

ГҮЙЛГЭЭГ СЭЖИГТЭЙ ГЭЖ ҮЗСЭН ТОХИОЛДОЛД ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ВЭ?



Сэжигтэй үйлдэл, сэжигтэй гүйлгээг хэрхэн таних вэ?

Сэжигтэй үйлдэл гэдэг нь тухайн харилцагчийг сэжигтэй гэж үзэх үндэслэл болсон дотоод итгэл үнэмшлээс эхэлдэг тул сэжигтэй үйлдлийг таних, нотлох амаргүй байдаг. Сэжигтэй гүйлгээ эсвэл үйл ажиллагаа нь ихэнхдээ хууль эрх зүй, эдийн засгийн болон санхүүгийн бодит үндэслэлгүй, мөн мөнгөн дүн, цаг хугацаа зэрэг нь харилцагчийн мэргэжлийн болон бизнесийн онцлог, хэв шинжтэй нийцэхгүй байх зэрэг онцлог шинж чанартай байдаг.

Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд дараах тохиолдлыг сэжигтэй үйлдэл, гүйлгээ гэж үзэх боломжтой бөгөөд үүгээр хязгаарлахгүй. Үүнд:

- Харилцагч өөрөө гэмт хэрэгтэй холбоотой гэдгээ мэдэгдсэн, зарласан;
- Харилцагч хувийн мэдээллээ өгөхөөс татгалзсан;
- Мөнгөний гарал үүслийн талаар тодорхой тайлбар өгөхөөс татгалзсан;
- Гүйлгээ, түүний агуулга, утгын талаар эргэлзээтэй тайлбар хэлэх;
- Данс нээсний дараа харилцагчийн гэрийн, эсвэл ажлын утасны дугаар нь холбогдохгүй байх;
- Харилцагч худал, хуурамч мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;
- Харилцагч биеэр ирэлгүйгээр санхүүгийн үйлчилгээ авахыг оролдох, тулган шаардах;
- Харилцагч санхүүгийн байгууллагын ажилтанд сэжигтэй, хэвийн бус гүйлгээг хийж өгсөн тохиолдолд мөнгөн болон бусад шагнал амлах, гүйлгээ хийхийг тулгаж шаардах;
- Харилцагч халхавч байгууллага буюу мөнгөн хөрөнгө, үйл ажиллагаа эсвэл биетээр оршдоггүй байгууллагатай холбоотой нь тогтоогдсон;
- Харилцагч гүйлгээг мэдээлэх босго дүн, баримт, материал хадгалах шаардлага, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанаас зайлсхийх зорилгоор гүйлгээний дүн, бүтцийг өөрчлөх;
- Их хэмжээний мөнгөн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээнүүдийг хууль эрх зүй, эдийн засгийн үндэслэлгүйгээр ойр ойрхон хийж эхэлж байгаа харилцагч;

- Эдийн засгийн илт үндэслэлгүй, хоорондоо уялдаа холбоогүй олон тооны цахим гүйлгээнүүд хийгдэх, тэр дундаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй, хар тамхины наймаа өргөн дэлгэрсэн, ФАТФ-ын хар жагсаалтад орсон орноос эсвэл орноор дамжуулан хийгдэж буй гүйлгээ.

Гүйлгээг сэжигтэй гэж үзсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-т заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн алба /СМА/-нд мэдээлнэ.” гэж заасан. Мэдээлэх үүрэгтэй этгээд гүйлгээг сэжигтэй гэж үзсэн, эсвэл мэдсэн тохиолдолд дараах арга хэмжээг авбал зохино. Үүнд:

1. Гүйлгээний талаар комплаенсын ажилтанд цаг алдалгүй мэдэгдэнэ;
2. Гүйлгээний талаарх бүх мэдээллийг, бичиг баримтын хуулбарыг авах;
3. Комплаенсын ажилтан гүйлгээг сэжигтэй гэж үзсэн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.2-т заасны дагуу “Сэжигтэй гүйлгээ болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын дагуу 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн алба /цаашид “СМА” гэх/-нд мэдээлнэ;
4. Мэдээлэх үүрэгтэй этгээд СМА-нд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг харилцагчид болон бусдад задруулахыг хориглоно.

Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд та бүхэн гүйлгээг сэжигтэй гэж үзсэн, тогтоосон тохиолдолд СМА-нд нэн даруй мэдээлж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.


ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 3 дугаар улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 130 өргөдөл, гомдол ирсэн байна.



Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбар болон ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо өссөн байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 130 өргөдөл, гомдол ирснээс:

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	108
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	22
Хугацааг нь сунган хянагдаж буй	-

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Өргөдөл, гомдол шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор):



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХЯМРАЛЫН ҮЕ ДЭХ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, компанийн удирдлагын зүй зохистой бүтэц суурийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын тогтолцоог сайжруулах гэсэн гол зарчмуудад компанийн засаглал тулгуурладаг. Энгийнээр хэлбэл компанийг зөв чиглүүлэх удирдлага-хяналтын тогтолцоог бий болгохыг л засаглалыг хөгжүүлэх, сайжруулах гэж хэлээд байгаа юм. Засаглал сайжирснаар улс оронд эдийн засгийн нээлттэй, тогтвортой байдлыг бий болгож, олон талт хамтын ажиллагаа, урт хугацааны хөрөнгийн олон эх үүсвэрийг татахад эергээр нөлөөлдөг. Тэгэхээр сайн засаглалын үр өгөөжийг хувь нийлүүлэгчид, компани, бүх оролцогч талууд, цаашлаад улс орон ч гэсэн хүртэх боломжтой гэсэн үг юм. Харин компаниудын хувьд засаглалаа сайжруулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бий болгосноор бүх оролцогч талуудтай хялбархан ойлголцолд хүрэх, хөрөнгийн шинэ эх үүсвэрүүдийг татах, компанийн нэр хүндээ дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоог компанийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлснээр шийдвэр гаргах процесс тодорхой болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Онцлоод хэлэхэд, Зөвхөн нээлттэй хувьцаат компани, эсхүл бизнес нь тодорхой хугацааны туршид үргэлжлэн тогтворжсон, олон хувьцаа эзэмшигчидтэй компани сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг, ингэснээр үр дүнг нь хүртдэг гэдэг нь өрөөсгөл ойлголт юм. Бодит амьдрал дээр том, бага, зохион байгуулалтын хэлбэр, дөнгөж үүсгэн байгуулагдсан, эсхүл үйл ажиллагаа нь тогтворжсон гэх зэргээс үл хамааран бүх л компаниудын өрсөлдөж буй бизнесийн орчинд сайн засаглал нь чухал ач холбогдолтой байдаг. Бүх компаниудад тохирох нэгэн ижил бус харин тухайн компанийн онцлогт тохирсон зохистой засаглал нь тухайн бизнесийн үйл ажиллагааны үр ашиг болон удаан хугацаанд амжилттай оршин тогтноход шууд эергээр нөлөөлдөг.

Одоо ч зарим хүмүүсийн дунд компанийн засаглалын олон улсын зарчмууд нь зөвхөн онолын шинжтэй, тэдгээрийг нэвтрүүлснээр бизнесийн үзүүлэлтэд шууд нөлөөлдөггүй, хэрэгжүүлэх зардал өндөр, хүнд суртал /шийдвэр гаргалтыг удаашруулдаг/-ыг бий болгодог, жижиг компанид тохиромжгүй гэх зэрэг ташаа ойлголтууд байсаар байна. Гэвч үнэн хэрэгтэй, хөрөнгө оруулалт татах, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах, хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ, шаардлагыг хангах, компанийг хөгжлийн дараагийн шатанд бэлтгэх зэрэгт компанийн зохистой засаглал зайлшгүй шаардлагатай юм.

Дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй салбар бүр санхүүгийн хүнд нөхцөлтэй тулгарч байгааг харж байна. Зарим улс орнууд цар тахалтай холбоотойгоор хорио цээрийн дэглэм тогтоож, нэг газар олон хүн цугларах, арга хэмжээ зохион байгуулахыг хориглосны улмаас нээлттэй компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахад зарим асуудлуудтай тулгарсан.

Манай улсын хувьд онцгой нөхцөл байдлаас шалтгаалан “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд нь хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор зарлан хуралдуулах боломжгүй болсон тул



СЗХ-ны зүгээс үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн хувьцаат компанийн ТУЗ-ийн зүгээс хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнаас хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах чиглэлийг өгсөн.

Цар тахлын үед хувьцаат компаниуд Компанийн тухай хуулийг хэрэгжүүлж чадсан хэдий ч хөрөнгө оруулагчдын бүртгэл, санал өгөх эрх, оролцоо болон санал хураалтын нууцлал зэрэгт тавигдах шаардлагыг хангах зэрэг асуудал нь сорилт болж байна. Мөн энэ нь хувьцаат компаниудад хувьцаа эзэмшигчдийн хурлаа зайнаас зохион байгуулахад шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна.

Мөн дэлхийн улс орны засгийн газруудын авч буй арга хэмжээ, хязгаарлалттай холбоотойгоор компаниуд дараах зүйлсэд анхаарч ажиллах шаардлагатай. Хувьцаа эзэмшигчдийн болон бизнесийн чухал шийдвэр гаргах хурал, уулзалтыг зайнаас шуурхай зохион байгуулах техник, технологийг бүрдүүлэх; өдөр тутмын үйл ажиллагаанд өөрчлөлт гарч, зайнаас ажиллах цахим мэдээллийн системийн шинэчлэлийг хийх; цар тахлын үед бизнесийн тасралтгүй байдлыг хангахуйц эрсдэлийн стратеги, менежментийг сайжруулах, хөрвөх чадвар сайтай байх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, Ковид 19-тэй холбоотойгоор бизнест үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөллийн цар хүрээг нарийвчлан үнэлэх, нөлөөллийг олон нийтэд мэдээлэх, бизнесийн ёс зүйтэй байх зэрэг юм.

Цаашид аливаа хямралын үед төр, бизнесийн хамтын ажиллагаа нягтарна гэж үзэхээр байна. Өөрөөр хэлбэл, томоохон хөрөнгө оруулалтын төслүүд зөвхөн хувийн компанийн асуудал байхаа болино. Төр тоглоомын дүрмийн зохиогчийн хувьд бизнесээс хөдөлмөр эрхлэлт, татвар, байгаль орчин, нийгмийн хамгааллын талаар эерэг үр дүнг гаргаж авахын тулд тухайн төслийг анхнаас нь төлөвлөхөд оролцох ба үүний хариуд бизнесийн зүгээс хямрал, гамшгийн үед төрөөс дэмжлэг авах боломж бүрдэх юм.

ОУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

УРТ ХУГАЦААНЫ, ТЭГШ БУС, ТОДОРХОЙГҮЙ ӨСӨЛТ

COVID-19 вирусн тархалтаас одоогийн байдлаар 1 сая гаруй хүний амь нас харамсалтайгаар алдсаар байгаа юм. Коронавирусын шинэ тахал нь урьд өмнө хэзээ ч байгаагүй тулгамдсан асуудал байсан ч дэлхий нийтээрээ дасан зохицож байна. Тусгаарлалтыг зөөлрүүлж, дэлхийн өнцөг булан бүрт төв банкнууд, засгийн газрууд урьд өмнө хэзээ ч байгаагүй бодлогын дэмжлэгийг түргэн шуурхай нэвтрүүлсний үр дүнд дэлхийн эдийн засаг энэ оны эхний хагаст уналтын цэгээс эргэн иржээ. Ажил эрхлэлт хямралын оргил үед огцом унасны дараа хэсэгчлэн сэргэсэн.


Гэсэнч энэ хямрал нь одоо хүртэл эцэслэгдээгүй байгаа юм. Ажил эрхлэлт нь тахлын өмнөх түвшингээс доогуур хэвээр байгаа бөгөөд хөдөлмөрийн зах зээлд бага орлоготой ажилчид, залуучууд, эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусаж байна. Энэ жил 90 сая орчим хүн туйлын хомстолд орох төлөвтэй байгаагаас харахад ядуучууд илүү ихээр ядуурав.

Иймд төсөв, мөнгөний бодлогын дэмжлэгийг аль болох эрт татаж авахгүй байх нь чухал юм. Дэлхийн өсөлт -4.4 хувь байх төлөвтэй байна. 2021 онд өсөлт нь 5.2 хувьд хүрч, 6-р сарын төсөөллөөс -0.2% -иар буурна гэж таамаглаж байна.

Энэ онд үйлдвэрлэлийн хэмжээ 2019 оны түвшингээс давах төлөвтэй байгаа Хятад улсаас бусад хөгжингүй эдийн засагтай, хөгжиж буй орнууд нь 2019 оны түвшингээс доогуур түвшинд байх төлөвтэй байгаа юм. Нефть экспортлогчдод илүү их найддаг улс орнууд үйлдвэрлэлийн тэргүүлэх эдийн засагтай харьцуулахад сул сэргэлттэй байна.

Энэхүү цар тахлын улмаас дэвшилтэт эдийн засагтай орнууд болон хөгжиж буй орнуудын (Хятадаас бусад) орлогын хэтийн төлөв дэх зөрүү улам бүр дордох төлөвтэй байгаа юм. 2020 онд хөгжингүй орнуудын эдийн засгийн төлөв -5.8 хувь болон дээшилж, дараа нь 2021 онд эдийн засгийн өсөлт сэргэж 3.9 хувь болохоор байна. Хөгжиж буй зах зээл болон хөгжиж буй орнуудын хувьд (Хятадыг эс тооцвол) 2020 онд өсөлт -5.7 хувь, дараа нь 2021 онд 5 хувь сэргэх төлөвтэй байгаа. Үүнтэй уялдан 2020-21 оны хооронд хөгжиж буй орнуудын (Хятадаас бусад) нэг хүнд ногдох орлогын хуримтлагдсан өсөлт нь хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтөөс доогуур байх төлөвтэй байгаа юм.

Тэгш бус нөхөн сэргэлтүүд



Эх сурвалж: Олон улсын валютын сан

2021 онд сэргэлтийн дараа дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд 3.5 орчим хувь болж аажмаар саарах төлөвтэй байна. Цар тахлын өмнөх төсөөлөлтэй харьцуулбал хуримтлагдсан алдагдал 2020-21 онуудад 11 их наяд байснаа 2020-25 онуудад 28 их наяд болж өсөх төлөвтэй гэж үзжээ. Энэ нь улс орны бүх бүлгийн амьжиргааны дундаж түвшинг дээшлүүлэхэд ноцтой ухралт болж байгааг харууллаа.

Орон нутгийн тусгаарлалтыг дахин сулласнаар вирусн тархалт дахин сэргэж байна. Хэрэв энэ байдал улам дордож, эмчилгээ, вакцины хэтийн төлөв муудвал эдийн засгийн үйл ажиллагаанд үзүүлэх хохирол маш хүнд байх бөгөөд санхүүгийн зах зээлийн хүчтэй үймээн самуун улам нэмэгдэж болзошгүй юм. Худалдаа, хөрөнгө оруулалтын хязгаарлалт ихсэж, геополитикийн эргэлзээ нэмэгдэж байгаа нь сэргэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Шинжилгээ, эмчилгээ, вакцин, бодлогын нэмэлт хөшүүргийг илүү хурдан, илүү өргөн хүрээнд ашиглах нь үр дүнг мэдэгдэхүйц сайжруулж чадна.

Илүү их арга хэмжээ авах шаардлагатай байна

12 их наяд доллартай тэнцэх дэлхийн санхүүгийн ихээхэн дэмжлэг, хүүг бууруулах, төв банкнуудын актив худалдан авах зэрэг нь хүний амь нас, амьжиргааг аварч, санхүүгийн сүйрлээс урьдчилан сэргийлэв.

Тогтвортой сэргэхийн тулд олон зүйлийг хийх шаардлагатай хэвээр байгаа юм. Нэгдүгээрт, энэхүү эрүүл мэндийн хямралыг зогсоохын тулд олон улсын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Туршилт, эмчилгээ, вакцин боловсруулах чиглэлээр асар их ахиц дэвшил гарч байгаа боловч улс орнууд нягт хамтран ажиллаж байж л дэлхийн өнцөг булан бүрт хангалттай хэмжээний үйлдвэрлэл, өргөн тархалт бий болно.

Хоёрдугаарт, аль болох бодлогын хувьд энэхүү хямралаас үүсэх эдийн засгийн тасралтгүй хохирлыг хязгаарлахад чиглэсэн бодлогыг эрчимтэй хэрэгжүүлэх ёстой. Засгийн газар орлогын дэмжлэгийг зорилтот бүлэгт чиглэсэн бэлэн мөнгөний шилжүүлэг, цалин хөлсний татаас, ажилгүйдлийн даатгал зэргээр үргэлжлүүлэн олгох шаардлагатай. Томоохон хэмжээний дампуурлаас урьдчилан сэргийлэх, ажилчдыг үр бүтээлтэй ажилдаа эргэж орох боломжийг бүрдүүлэхийн тулд эмзэг боловч үйл ажиллагаагаа явуулах чадвартай компаниуд татвараа хойшлуулах, өр төлбөрийг зогсоох зэргээр боломжит бүх тохиолдолд дэмжлэгээ үргэлжлүүлэн авах хэрэгтэй.

Ажилчдыг орлогын шилжүүлэг, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх зэргээр дэмжих хэрэгтэй. Хөгжиж буй зах зээл, хөгжиж буй эдийн засагтай орнууд энэ хямралыг цөөн хэмжээний нөөцөөр зохицуулах шаардлагатай болж байна. Эдгээр эдийн засаг нь эрүүл мэнд, ядуу иргэдэд шилжүүлэхэд шаардагдах чухал ач холбогдолтой зардлыг эрэмбэлж баталгаажуулах шаардлагатай болно. Өр төлбөр тогтворгүй байгаа тохиолдолд энэ хямралыг даван туулж санхүүгээ чөлөөлөхийн тулд бүтцийн өөрчлөлтийг эрт хийх хэрэгтэй.

Дэлхийн хэмжээнд мөнгөний бодлогыг зөөлрүүлэх нь сэргэхэд зайлшгүй шаардлагатай боловч дунд хугацаанд санхүүгийн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, төв банкны хараат бус байдлыг ямар ч хамаагүй байдлаар хамгаалах ёстой. Төсвийн хэрэгцээ нь дэлхийн улс орнуудын өрийн түвшинг дэлхийн ДНБ-ий 100 хувьтай тэнцэх хэмжээнд хүргэж байна.

Эрүүл мэнд, дижитал дэд бүтэц, ногоон дэд бүтэц, боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт нь үр өгөөжтэй, хүртээмжтэй, тогтвортой өсөлтөд хүрэхэд тусална. Одоогийн эдийн засгийн хямрал нь Их хямралаас хойш гарсан хамгийн хүнд хямрал бөгөөд үүнээс гарахын тулд үндэсний болон олон улсын түвшинд бодлогын фронтод томоохон шинэчлэл хийх шаардлагатай болно.

Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн хамгийн сүүлийн үеийн төсөөлөл

(Бодит ДНБ, жилийн хувийн өөрчлөлт)	2019	2020	2021
Дэлхий	2.8	-4.4	5.2
Дэвшилтэт эдийн засагтай орнууд	1.7	-5.8	3.9
АНУ	2.2	-4.3	3.1
Евро бүс	1.3	-8.3	5.2
Герман улс	0.6	-6.0	4.2
Франц улс	1.5	-9.8	6.0
Итали улс	0.3	-10.6	5.2
Испани улс	2.0	-12.8	7.2
Япон улс	0.7	-5.3	2.3
Английн Нэгдсэн Вант Улс	1.5	-9.8	5.9
Канад улс	1.7	-7.1	5.2
Бусад дэвшилтэт эдийн засагтай орнууд	1.7	-3.8	3.6
Хөгжиж буй зах зээл болон эдийн засагтай орнууд	3.7	-3.3	6.0
БНХАУ	6.1	1.9	8.2
Энэтхэг улс	4.2	-10.3	8.8
Зүүн Өмнөд Азийн үндэстнүүдийн холбоо	4.9	-3.4	6.2
Хөгжиж буй зах зээл болон эдийн засагтай Европ	2.1	-4.6	3.9
ОХУ	1.3	-4.1	2.8
Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд	0.0	-8.1	3.6
Бразил улс	1.1	-5.8	2.8
Мексик улс	-0.3	-9.0	3.5
Ойрхи Дорнод ба Төв Ази	1.4	-4.1	3.0
Саудын Араб	0.3	-5.4	3.1
Саб Сахарын Африк	3.2	-3.0	3.1/
Нигери улс	2.2	-8.0	3.0
Өмнөд Африка	0.2	-8.0	3.0
Бага орлоготой хөгжиж буй орнууд	5.3	-1.2	4.9




САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ

2020
09


Хөрөнгийн зах зээл

ЗЗҮ /их наяд төгрөг/




Дунджаар 2.59 их наяд төгрөгт хүрсэн.

ТОП-20 индекс




17,176.2 буюу өмнөх сарын дунджаас 457.4 индексээр өссөн.

MSE A индекс



8,248.7 буюу өмнөх сарын дунджаас 102.4 индексээр нэмэгдсэн.

MSE Б индекс



7,406.0 буюу өмнөх сарын дунджаас 15.6 индексээр нэмэгдсэн.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, www.mse.mn

Бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг

15,138,005,043

Хоёрдогч хувьцааны арилжааны үнийн дүн

/тэрбум төгрөг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Биелсэн хэлцэл

290

Богцын нийт хэмжээ

278,060

Богцын нийт үнийн дүн

169.5


/тэрбум төгрөг/

Нэгж богцын дундаж үнэ


597,8

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж, www.mse.mn


Americas



Asia Pacific



Europe, Middle East & Africa




**ОЛОН
УЛСЫН**

**ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛ**


2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар

Эх сурвалж: www.bloomberg.com

2020
09




		2020.08 сар	2020.09 сар	Өөрчлөлт
Зэс	А зэрэглэлийн, Лондонгийн металлын бирж, тонн тутмын ам.доллар	6,508.4	6,704.9	3.0%
Алт	Лондонгийн гулдмайн зах зээлийн холбоо, 3 цагийн тогтмол ханш, унц тутмын ам.доллар	1,968.0	1,922.2	-2.3%
Мөнгө	Лондонгийн гулдмайн зах зээлийн холбоо, унц тутмын ам.доллар	26.9	25.9	-3.8%




Эх сурвалж: www.data.imf.org

	2020.08 сар	2020.09 сар	Өөрчлөлт
Молибден	16,699.5	18,258.3	9.3%
Никель	14,575.8	14,857.5	1.9%
Цагаан тугалга	17,660.4	17,951.3	1.6%



Эх сурвалж: www.data.imf.org

	2020.08 сар	2020.09 сар	Өөрчлөлт
Хөнгөн цагаан	1,738.6	1,743.8	0.3%
Төмрийн хүдэр	120.1	123.0	2.4%
Хар тугалга	1,936.3	1,872.9	-3.3%
Цайр	2,413.9	2,442.5	1.2%




Эх сурвалж: www.data.imf.org

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

S&P 500 /^GSPC/


3,443.12 -7.56 (-0.22%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


23,312.14 -165.19 (-0.70%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/

5,829.50 -46.78 (-0.81%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Dubai Financial Market General Index DFMGI:IND

2,176.72 +5.54 (+0.26%)



Эх сурвалж: www.Bloomberg.com

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia